



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 05 дугаар сарын 01
№17 (1412)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

52. Хэлэлцээр соёрхон батлах тухай 807

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

53. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн
2025 оны 12 дугаар дүгнэлтийн тухай Дугаар 04 808
54. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн
2026 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай Дугаар 05 810
55. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 08 812
56. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай Дугаар 09 814

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

57. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1,
102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох
зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн
эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 12 818
58. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх
ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол
Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай Дугаар 01 842

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

59. Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс
болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын
хэлэлцээр 863

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. ...” гэж заасанд нийцээгүй байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор ... шийдвэрлэнэ.” гэж заасанд нийцээгүй байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасанд нийцээгүй байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нараас 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 17-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайхан, Нямтайширын Номтойбаяр, Баттөмөрийн Энхбаяр нарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Жаргалсайханы Золжаргал, Цагаанхүүгийн Идэрбат, Баатаржавын Мөнхсоёл нарыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Далайн Батбаяр, Батмөнхийн Батцэцэг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Саруулсайханы Цэнгүүн, Сүхбаатарын Эрдэнэбат нарыг Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны, Цагаанхүүгийн Идэрбат, Чинбатын Номин, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Жуковын Алдаржавхлан, Загджавын Мэндсайхан нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Сайнбуянгийн Амарсайханыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Дамбын Батлут, Бадрахын Найдалаа нарыг Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны, Жуковын Алдаржавхлан, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Пүрэвжавын Ганзориг, Бадрахын Найдалаа нарыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Батын Батбаатар нарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Далайн Батбаяр, Батмөнхийн Батцэцэг нарыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Цагаанхүүгийн Идэрбатыг Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны, Болдын Жавхлан, Бадрахын Найдалаа, Чинбатын Ундрэм, Баттогтохын Чойжилсүрэн, Баттөмөрийн Энхбаяр нарыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Хассуурийн Ганхуяг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Дамбын Батлут, Саруулсайханы Цэнгүүн нарыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Пүрэвжавын Ганзориг, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарыг Улсын Их Хурлын Хүний



хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны, Жаргалсайханы Золжаргал, Баатаржавын Мөнхсоёл, Загджавын Мэндсайхан, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэбат нарыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3.Энэ тогтоолыг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2025 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар
зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт
Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 11.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан /даргалагч/, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, О.Мөнхсайхан /илтгэгч/, Ц.Цолмон, Б.Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Д.Отгонбаяр, С.Номынбаясгалан нар оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Дөчин гуравдугаар зүйлийн 1, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

**Нэг. Монгол Улсын иргэн Ш.Тэгвандан Үндсэн хуулийн цэцэг
хандан ирүүлсэн мэдээлэлдээ:**

“Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэх хугацааг 3 хоногийн дараа гэсэн нь 3 хоногоос хойш гэсэн үг биш бөгөөд 3 хоногийн дараагаас эхлэн, саналыг тавьснаас хойш 10 хоногийн дотор буюу 7 хоногт хэлэлцэн шийдвэрлэхээр тодорхой заасан байна. Харин Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн, саналыг тавьснаас хойш 10 хоногийн дотор буюу 3 хоногийн дотор шийдвэрлэхээр заасан нь Улсын Их Хурлын тус асуудлыг хэлэлцэх хугацааг 4 хоногоор багасгасан байна.

Иймд тус хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн болохыг тогтоож өгнө үү.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын иргэн Д.Отгонбаяр Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн мэдээлэл, ихэсгэсэн шаардлагадаа:

“Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэх тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан тохиолдолд уг тогтоолын төслийг Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэх, эсхүл 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэх эсэхэд Үндсэн хуулийн зөрчил үүссэн байна. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хурал Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэхээр, харин Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт зааснаар уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэхээр тус тус заасан нь Үндсэн хуульд заасан хугацаатай зөрчилдөж байна.

Хууль тогтоох байгууллагаас батлан гаргаж буй хууль тогтоомж, шийдвэр гаргах процесс нь Үндсэн хуулийн үзэл баримтлалтай бүрнээ нийцэх, ил тод, хариуцлагатай, ардчилсан зарчмаар явагдаж хууль ёсны байдлыг хангах шаардлагатай. Мөн хууль дээдлэх зарчмын агуулга нь эрх зүйн эх сурвалжууд бие биеэ шатлан захирах, ерөнхий байх, тодорхой байх, тогтвортой байх, нийцсэн байх гэх мэт агуулгыг багтаадаг ойлголт юм. Харин Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт заасан 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэх хугацааг баримтлах нь эрх зүйн эх сурвалжууд бие биеэ шатлан захирах зарчмыг зөрчсөн үйлдэл болно.

Иймд тус хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн дүгнэлт гаргаж өгөхийг хүсье.” гэсэн байна.

Гурав. Монгол Улсын иргэн С.Номынбаясгалан Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн мэдээлэлдээ:

“Үндсэн хуульд баталгаажуулсан хууль дээдлэх зарчмын гол агуулга нь нийт байгууллага, иргэний аливаа үйл ажиллагаа Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байхын зэрэгцээ хуулийн хүрээнд явагдах агуулгыг илэрхийлнэ. Хууль дээдлэх зарчмын суурь болох Үндсэн хуулийг дээдлэх үзэл баримтлалын үүднээс авч үзвэл Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхий сайдыг огцруулах саналыг, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг тус тус Улсын Их Хурал “... гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав

хоногийн дотор ...” шийдвэрлэхээр тодорхой хугацааг шууд нэрлэн заасан нь энэ хугацаанаас өөрөөр тогтоохыг зөвшөөрөөгүй байна. Хэрэв ийнхүү шууд нэрлэн заасан тодорхой хугацаанаас өөрөөр тогтоосон бол Үндсэн хуулийн зөрчил болно. Тиймээс хууль тогтоогч Үндсэн хуульд шууд нэрлэн заасан тодорхой хугацааг багасгах, эсхүл нэмэх зэргээр өөрчлөлт оруулах нь хууль зүйн хувьд боломжгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт Ерөнхий сайдыг огцруулах саналыг, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг тус тус “... 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэж Үндсэн хуульд заасан хугацааг нэмж өөрчилсөн байна. Ийнхүү Үндсэн хуульд шууд нэрлэн заасан тодорхой хугацааг өөрчилсөн нь хууль дээдлэх зарчмын агуулгад нийцэхгүй байна. Одоо үйлчилж буй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн уг агуулга өмнө нь үйлчилж байсан 2020 оны Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсэгтэй адил байна. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогч Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг хуулиар батлахдаа Үндсэн хуулийн холбогдох хэсгийг удаа дараа зөрчсөн байна.

Иймд тус хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг, түүнчлэн тус хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгож өгнө үү.” гэжээ.

Дөрөв. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“... Улсын Их Хурлаас 2023 онд Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж бүхэлд нь өөрчлөн найруулсан.

Уг өөрчлөлтөд нийцүүлэн боловсруулж, 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын

чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэгт "... Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ..." гэж, 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсэгт "... Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ..." гэж тус тус заасан өмнөх зохицуулалтыг хөндөлгүй хэвээр өргөн мэдүүлжээ. Төслийг Улсын Их Хурлын Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд дээрх асуудлаар гишүүд, ажлын хэсгээс санал гараагүй болно.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэж буй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дээрх хэсэгт зохих өөрчлөлт оруулахаар тусгасан болно. Түүнчлэн М.Бадамсүрэн нарын Улсын Их Хурлын гишүүдээс 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийг Үндсэн хуулийн холбогдох хэсэгтэй нийцүүлж өөрчлөхөөр тусгасан." гэжээ.

Тав. Маргааныг Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд бэлтгэх хүрээнд дараах баримт бичиг, шийдвэр, судалгаа, эх сурвалжтай танилцаж, холбогдох эрх бүхий этгээдээс тайлбар, лавлагаа гаргуулан авсан болно:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн холбогдох шийдвэр (Цэцийн магадлал, дүгнэлт, тогтоол, Цэцийн гишүүний тогтоол);

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2019.06.06), түүний үзэл баримтлал, танилцуулга, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл, судалгаа, холбогдох бусад баримт;

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (2024.04.05), түүний үзэл баримтлал, танилцуулга, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл;

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (2025.11.14), түүний үзэл баримтлал, танилцуулга;

Монгол Улсын Их Хурал, "Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай" тогтоолын төсөл (2025.05.28), Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл;

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар, 2019;

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Албан бичиг, 2025.06.16, №ТГ-02/726; 2025.12.18, №ТГ-02/1434; 2025.12.22, №ТГ-02/1448;

О.Машбат, Шинжээчийн дүгнэлт, 2025.10.20;
Венецийн комисс, Парламент ба Засгийн газрын харилцаа: итгэл болон хариуцлагын тухай тайлан, 2024.06.24, CDL-AD(2024)016.

ҮНДЭСЛЭЛ:

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль (цаашид “Үндсэн хууль” гэх)-аар парламентын тогтолцоог бий болгосон бөгөөд парламентын тогтолцоо нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд багтаж хамгаалагдана (Цэцийн тогтоол, 2022, №02). Монгол Улсын Их Хурал (цаашид “Улсын Их Хурал” гэх) нь ард түмнээс сонгож байгуулагдсан төлөөлөгчдийн дээд байгууллага тул “төрийн эрх барих дээд байгууллага” мөн (Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл). Иймээс Улсын Их Хурал нь төрийн гүйцэтгэх дээд байгууллагыг бүрдүүлэх болон түүний үйл ажиллагаанд шийдвэрлэх нөлөөтэй. Өөрөөр хэлбэл, парламентын тогтолцоонд Засгийн газар нь легитим шинжээ парламентаас, тодруулбал түүний дэмжлэгийг авах чадвараас олдог. Тиймээс ардчилсан сонгуулиар бүрдсэн Улсын Их Хурал нь Ерөнхий сайдыг томилох замаар Засгийн газрыг эмхлэн байгуулах чиг үүрэгтэй (Цэцийн дүгнэлт, 2025, №09). Засгийн газар нь Улсын Их Хуралд үйл ажиллагаагаа тайлагнаж, түүний өмнө танхимаараа хариуцлага хүлээх (Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг) бөгөөд Улсын Их Хурлын олонхын итгэл дээр тулгуурлан оршино. Ерөнхий сайд буюу Засгийн газар уг итгэлийг алдвал огцрохоор Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тусгайлан зохицуулжээ.

Энэхүү маргаан нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсгийн Ерөнхий сайдыг огцруулах саналыг шийдвэрлэх зохицуулалт нь Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 хэсэгт, мөн хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх асуудлыг шийдвэрлэх зохицуулалт нь Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус нийцсэн эсэхтэй холбоотой байх тул Үндсэн хуулийн эдгээр зүйлийн агуулгыг тайлбарласны үндсэн дээр зөрчигдсөн эсэхийг шалгаж тогтооно.

Нэг. Ерөнхий сайдыг огцруулах талаарх зохицуулалт

1.1. Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг Үндсэн хуульд тусгасан нь

Парламентын тогтолцоонд Засгийн газар парламентын өмнө хариуцлага хүлээнэ. Энэ хариуцлага нь ердийн шүүмжлэл зэрэг албан бус хэлбэрээс гадна парламентын гишүүн чуулганы хуралдаанд үг хэлэх, асуулт тавих, асуулгын хариуг хэлэлцүүлэх зэрэг хуулиар зохицуулсан,

албан ёсны хэлбэртэй. Засгийн газар парламентын өмнө хариуцлага хүлээх хамгийн эцсийн, хүчтэй хэлбэр нь Ерөнхий сайдыг огцруулах санал хураалт (олон улсад үүнийг “the vote of no confidence” буюу “итгэл эс үзүүлэх санал хураалт” гэдэг) юм. Ерөнхий сайдыг огцруулах саналыг парламент санаачилж, Ерөнхий сайд үргэлжлүүлэн ажиллах эсэхийг хэлэлцэж шийдвэрлэдэг. Энэ санал нь парламентаас Ерөнхий сайд буюу Засгийн газарт үзүүлсэн итгэлээ буцаах тухай хүсэл зоригоо албан ёсоор илэрхийлж буй явдал бөгөөд түүнийг дэмжвэл Ерөнхий сайд болон Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох үр дагавартай.

1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад Ерөнхийлөгч “... Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах;” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр зааж, Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан болон Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавьбал Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэж анх зохицуулжээ. Түүнчлэн Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний дийлэнх олонхи нь хүрэлцэн ирснээр чуулганыг хүчинтэйд үзэж, чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.” гэж анх заасан байсан бол 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг хэсгийг “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. ...” гэж өөрчлөн найруулсан байна.

Дээрхээс үзэхэд, Засгийн газрыг огцруулах саналыг Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн тэн хагас, Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй гэсэн дөрвөн этгээд тавих боломжтой бөгөөд Улсын Их Хурал уг саналыг 15 хоногийн дотор хэлэлцэж, чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар (ердийн олонхоор) шийдвэрлэхээр хэт ерөнхий зохицуулсан байсан нь Засгийн газрын бие даасан, тогтвортой байдлыг алдагдуулахад нөлөөлж байсан гэж үздэг. Түүнчлэн 1992 оны Үндсэн хуулийн уг эхийн дагуу Засгийн газрыг огцруулахдаа Улсын Их Хурал огт эрсдэл хүлээдэггүй тул хариуцлагагүй



ханддаг байсан гэж дүгнэжээ. Засгийн газрыг огцруулсан бол шинэ Ерөнхий сайдыг томилох хугацааг Үндсэн хуульд тогтоогоогүй, ийнхүү томилоогүй бол Улсын Их Хурлыг тараах зохицуулалт байгаагүйгээс Засгийн газрыг огцруулах саналыг удаа дараа тавьж, Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг байжээ. Тухайлбал, 1992-2019 оны хооронд 14 удаа Засгийн газрыг байгуулж, нэг парламентын бүрэн эрхийн хугацаанд дөрвөн Засгийн газар солигдох тохиолдол ч гарч, улмаар Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дунджаар 1.8 жил болсноос нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлогыг тууштай хэрэгжүүлж, үр дүнг нь үзэх боломжийг хязгаарлаж, ардчилсан дэглэмд итгэх иргэдийн итгэлийг сулруулж байсан байна (Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, 2019, х. 3-4; Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, 2019.06.14, х.17-24). Түүнчлэн Засгийн газрыг огцруулсны дараа шинэ Ерөнхий сайдыг томилохгүй удах, тухайлбал 1998 онд Засгийн газар зургаан сарын турш үүрэг гүйцэтгэгч бүрэлдэхүүнтэйгээр ажилласан тохиолдол гарч байжээ.

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газрын бие даасан, тогтвортой, хариуцлагатай байдлыг хангах, танхимын зарчмыг бэхжүүлэх зорилгоор Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын бүрэн эрхийг хумьж, Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулсан байна. Тодруулбал, тус зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.” гэж тусгажээ. Энэ зохицуулалтаар Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэн гаргахыг зааж, уг саналыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх хугацааг нарийвчилж, шийдвэрлэх босгыг өндөрсгөн, санал хураалтын агуулга, үр дагаврыг тодорхойлсон байна.

2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж өөрчлөн найруулсан. Олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн төлөөлөх тогтолцооны аль алиных нь давуу талыг хослон хэрэгжүүлэх, олон намын тогтолцоог бэхжүүлэх, сонгуулийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах үүднээс Улсын Их Хурлын сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульд ийнхүү

тусгасан байна (Цэцийн дүгнэлт, 2025, №09). Гэвч олныг төлөөлөх тогтолцоотой харьцуулахад холимог тогтолцоо нь аль ч нам, эвсэл Улсын Их Хуралд олонхын суудал авахгүй байх, нам, эвсэл зөвшилцөн Засгийн газар байгуулах, уг зөвшилцөл задарч, Улсын Их Хурал дахь олонх тогтворгүй болох магадлалыг нэмэгдүүлэх учраас Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн агуулгыг зөв ойлгож хэрэгжүүлэх нь Засгийн газрын хариуцлагатай, үр нөлөөтэй байдлыг тэнцвэржүүлэх, улмаар хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хяналт, тэнцлийг хангахад чухал ач холбогдолтой.

1.2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсгийн тухайд

2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хүрээнд Улсын Их Хурал 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчлэн найруулахдаа тус хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэгт “Гишүүд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж заажээ. Түүнчлэн 2023 онд Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан Улсын Их Хурлаас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинээр батлахдаа тус хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “Гишүүд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж зааж, 2020 оны мөн хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэгтэй адилхан зохицуулжээ.

Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн агуулгыг тайлбарлаж, түүнд 2024 оны Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг нийцсэн эсэхийг шалгахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна:

1.2.1.Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал ...” гэж хэдэн гишүүн ямар саналыг Улсын Их Хуралд хандаж тавих талаар тусгажээ. 2023 онд Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, Улсын Их Хурал 76 гишүүнтэй байсныг 126 гишүүнтэй болгож нэмсэн тул түүний гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь буюу 32, эсхүл түүнээс дээш гишүүн Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор Улсын Их



Хуралд тавих (Цэцийн дүгнэлт, 2025, №08) бөгөөд үүнээс доош тооны гишүүн, эсхүл Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүн зэрэг бусад этгээд уг саналыг тавихыг зөвшөөрөөгүй байна. Учир нь Ерөнхий сайд буюу Засгийн газар гагцхүү Улсын Их Хурлын өмнө хариуцлага хүлээх тул түүнийг огцруулж улс төрийн хариуцлага хүлээлгэх санаачилгыг зөвхөн Улсын Их Хурлаас гаргах бөгөөд ийм санаачилгыг бусад этгээд гаргах нь парламентын тогтолцооны мөн чанарт нийцэхгүй. Түүнчлэн Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах (Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг) бөгөөд Засгийн газар танхимын зарчмаар ажиллах тул Ерөнхий сайдыг буюу Засгийн газрыг огцруулах саналыг Засгийн газрын гишүүн дангаараа, эсхүл хамтран гаргах нь Үндсэн хуульд нийцэхгүй.

Засгийн газрын гишүүнд хариуцлага тооцох буюу түүнийг огцруулах асуудлыг зөвхөн Ерөнхий сайд шийдвэрлэх бөгөөд Засгийн газрын гишүүнийг огцруулах саналыг тавих бүрэн эрхийг Улсын Их Хурлын гишүүдэд Үндсэн хуулиар олгоогүй байна (Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг). Засгийн газрын гишүүнийг огцруулах асуудлыг Улсын Их Хурлын гишүүний саналаар Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэх нь танхимын зарчмаар ажиллах Үндсэн хуулийн үзэл баримтлалтай харшилна (Цэцийн дүгнэлт, 2015, №11; Цэцийн тогтоол, 2015, №09). Тиймээс Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрын аль нэг гишүүнийг бус, харин зөвхөн Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавих боломжтой байх бөгөөд энэ санал нь Засгийн газрыг бүрэлдэхүүнээр нь огцруулах үр дагавартай юм (Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг).

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “Гишүүд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан бол ...” гэж заажээ. Энэхүү заалтын “гишүүд” гэдэг нь Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй ...” гэж шууд ойлгогдохгүй байх тул уг заалтыг боловсронгуй болгох шаардлагатай байгааг дурдах нь зүйтэй.

1.2.2. Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэж эхлэх болон шийдвэрлэх хугацааны хязгаарыг тодорхой заажээ. Тодруулбал, тус хэсгийн “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэдэг нь Ерөнхий сайдыг огцруулах санал тавьсан өдрөөс хойш 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэх агуулгатай. 3 хоногийн дараа хэлэлцэх хугацааг ийнхүү заасан нь уг хугацаанд Улсын Их Хурлын гишүүн бүр Ерөнхий сайдыг огцруулах саналтай тэгш эрхтэйгээр танилцах, судлах, асуулт, саналаа боловсруулах,

Ерөнхий сайд хариу тайлбараа бэлтгэх боломж олгох зорилготой тул уг саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан даруйд Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлэх нь зүйтэй байна (Цэцийн дүгнэлт, 2025, №08).

Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьснаас хойш “... арав хоногийн дотор ...” уг саналыг шийдвэрлэхээр зохицуулсан байна (Цэцийн дүгнэлт, 2025, №08). Энэ заалт нь уг саналыг тавьснаас хойш 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэх, ийнхүү хэлэлцэж эхэлснээс хойш 7 хоногийн дотор шийдвэрлэх утгатай. Өөрөөр хэлбэл, Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хурал хэлэлцэх дээд хугацаа нь 7 хоног байна.

Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэж эхлэх болон шийдвэрлэх хугацааны хязгаарыг тогтоосон нь Улсын Их Хурлын гишүүд уг саналыг судалж, бэлтгэл хангах, Улсын Их Хурал дээр нухацтай хэлэлцэх, боломжит хугацаанд шийдвэрлэхэд төдийгүй иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахад чиглэсэн байна. Хэрэв ийм хугацааг Үндсэн хуулиар тогтоогоогүй нөхцөлд Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэхгүй, шийдвэрлэхгүй байх, эсхүл хэт олон хоног хэлэлцэж сунжруулах, Засгийн газрын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зэрэг эрсдэл үүснэ.

Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьснаас хойш “... гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. ...” гэж Үндсэн хуулийн бичвэрт заасан байхад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж өөрчилжээ. Өөрөөр хэлбэл, “... гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэж Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт илт тодорхой заасан хугацааг маргаан бүхий хуулийн заалтаар “... 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэж 4 хоногоор уртасгаж, улмаар Улсын Их Хурал Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэж эхэлснээс хойш шийдвэрлэх дээд хугацааг 7 хоног байхаар заасныг 3 хоног болгон богиносгосон байх тул Үндсэн хуулийн дээрх заалтыг ноцтой зөрчсөн байна.

Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан даруйд гишүүдэд хүргүүлэхийг үүрэгжүүлсэн зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгаагүй байгаа нь Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэх шаардлага зөрчигдөх нөхцөлийг бий болгохоор байна. Тухайлбал, Улсын Их Хурлын нэр бүхий

54 гишүүн 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр “Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай” саналыг Улсын Их Хурлын даргад тавьсан ч 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр буюу уг саналыг тавьснаас хойш 3 хоногийн дараа Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлсэн зөрчил гарсныг Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 08 дугаар дүгнэлтэд тэмдэглэсэн байна.

Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавьснаас хойш “... гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. ...” гэж заасан учраас Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр уг саналыг энэ хугацааны дотор удаашралгүй хэлэлцэж шийдвэрлэх шаардлагатай. Гэтэл Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр удаашралгүй хэлэлцэж шийдвэрлэх талаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгайлан заагаагүй байгаа нь уг саналыг 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэх Үндсэн хуулийн шаардлага зөрчигдөх эрсдэл үүсгэсэн байна.

Ерөнхий сайдыг огцруулах саналыг Байнгын хороогоор хэлэлцүүлэх нь хугацаа алдаж, Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор ...” шийдвэрлэхээр тогтоосныг зөрчих эрсдэлийг нэмэгдүүлэхээр байна. Түүнчлэн парламентын болон хагас ерөнхийлөгчийн тогтолцоотой бусад улсын сайн туршлагаас үзэхэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Серби Улс, Бүгд Найрамдах Польш Улс зэрэг улсад Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх (итгэл үзүүлэх) болон Ерөнхий сайдыг огцруулах (итгэл эс үзүүлэх) саналыг парламентын нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцдэг байна. Энэ талаар “Ерөнхий сайдад итгэл үзүүлэх, эс үзүүлэх асуудлыг хэлэлцэхэд парламентын байнгын хороо оролцдоггүй байна. Байнгын хороо бол хууль тогтоох ердийн үйл ажиллагааны нэг хэсэг бөгөөд ерөнхийлөгчийн болон парламентын засагтай эсэхээс үл хамааран хууль тогтоох үйл ажиллагаанд голлох үүрэгтэй оролцдог. Харин парламентын засгийн онцлогтой холбоотой, төрийн эрх мэдлийн хяналт, тэнцлийн асуудалд, тухайлан итгэл үзүүлэх, эс үзүүлэх зэрэг асуудалд шууд оролцох үүрэг хүлээхгүй байгааг гадаад улс орнуудын Үндсэн хуулийн заалт, парламентын чуулганы хуралдааны дэг зэргээс нийтлэг ажиглагдаж байна” гэж дүгнэжээ (Шинжээчийн дүгнэлт, 2025.10.20, х.13). Иймээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсэгт “Төрийн байгуулалтын байнгын хороо Ерөнхий сайдыг огцруулах саналыг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд танилцуулна.” гэж, мөн зүйлийн 101.3 дахь хэсэгт “Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, ил

санал хураалт явуулна.” гэж зайлшгүй зохицуулах шаардлагатай эсэхийг нягталж, уг зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй байна.

1.2.3. Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрт “... Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд ...” тооцохоор заасан. Энэ өгүүлбэрийн “уг санал” гэдгийг тус хэсгийн 1 дэх өгүүлбэрт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь албан ёсоор тавьсан “Ерөнхий сайдыг огцруулах санал” гэж ойлгох (Цэцийн дүгнэлт, 2025, №08) тул энэ нь санал хураах томъёоллын агуулга мөн. Иймээс Ерөнхий сайдыг огцруулах тухай санал нь Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлбэртэй байх бөгөөд Ерөнхий сайдыг огцруулахыг дэмжих буюу Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлахыг дэмжих агуулгаар санал хураахаар байна.

Улсын Их Хурал 126 гишүүнтэй тул “нийт гишүүний олонх” гэдэгт 64, эсхүл түүнээс дээш тооны гишүүнийг ойлгоно. Иймд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж (Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэг), Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлахыг дэмжих агуулгаар санал хурааж, нийт гишүүний олонх буюу туйлын олонх дэмжсэн бол уг тогтоолыг баталсанд тооцох нь Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийцнэ. Харин Үндсэн хуульд үүнтэй адилаар өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар буюу ердийн олонхоор асуудлыг шийдвэрлэнэ (Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэг).

Үндсэн хуульд байгаа нэр томъёог аль болох нэг мөр хэрэглэвэл зохих бөгөөд түүнийг өөрчлөн хэрэглэснээр агуулгын алдаа гаргах магадлалтай. Иймээс Үндсэн хуульд заасан нэр томъёо, агуулгыг бусад хууль тогтоомжид нэг мөр тусган хэрэглэх шаардлагатай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “... уг асуудлыг ...” шийдвэрлэхээр заасан байна. Энэ хэсгийн “уг асуудал” гэдэгт юуг хамааруулах нь бүрхэг байх тул үүнийг Ерөнхий сайдыг огцруулах саналаас өөрөөр ойлгох эрсдэл үүсгэсэн байна. “Уг асуудал” гэдгийг “Ерөнхий сайдыг огцруулах санал”-аас илүү өргөн, эсхүл салаа утгаар хэрэглэх боломжтой байх тул эрх зүйн тодорхой байдлыг хангахгүй байна. Тухайлбал, Ерөнхий сайдыг огцруулах эсэхийг шийдвэрлэхдээ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд “Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье” гэсэн томъёоллоор санал хураасан нь Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж тогтоосон (Цэцийн дүгнэлт, 2025, №08). Иймд дээрх хэсэгт “уг асуудал” гэж заасан нь Ерөнхий сайдыг огцруулах



тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлахыг дэмжих агуулгаар санал хураах утгыг алдагдуулж, Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийцээгүй байна.

1.2.4. Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлд Ерөнхий сайдыг огцруулах санал хураалтын үр дагаврыг зохицуулсан байна. Тухайлбал, Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын дэмжлэг аваагүй бол тус тогтоол батлагдаагүйд тооцож, Ерөнхий сайд огцрохгүй бөгөөд түүний Засгийн газар үргэлжлүүлэн ажиллана.

Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрт зааснаар Улсын Их Хурлын нийт гишүүний олонх Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжсэн бол тус тогтоолыг баталсанд тооцох бөгөөд үүнээс хойш 30 хоногийн дотор Улсын Их Хурал Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шинэ Ерөнхий сайдыг томилно. Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоолыг ийнхүү баталсанд тооцсоноор Ерөнхий сайд, мөн Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно (Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг). Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоолыг баталснаас хойш 30 хоногийн дотор шинэ Ерөнхий сайдыг томилоогүй бол Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргахаар байна.

Парламентын тогтолцоотой улсад Засгийн газарт хүлээлгэх эцсийн хариуцлага бол түүнийг буюу Ерөнхий сайдыг огцруулах саналыг парламентад тавьж шийдвэрлүүлэх байдаг бол парламентад хүлээлгэх хариуцлага нь түүнийг тараах явдал юм. Тухайлбал, Ерөнхий сайдыг томилох (сонгох) замаар Засгийн газрыг эмхлэн байгуулах, Ерөнхий сайдыг дэмжих замаар гүйцэтгэх эрх мэдлийн хэвийн үйл ажиллагааг хангах нь парламентын чиг үүрэгт багтана (Цэцийн дүгнэлт, 2025, №09). Парламент Ерөнхий сайдыг Үндсэн хуульд заасны дагуу томилоогүй нь чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгааг илтгэх тул тухайн парламентыг тараах нөхцөл болно. Ийнхүү тараах нь парламент, түүний олонхыг бүрдүүлж байгаа нам, эвсэлд улс төрийн хариуцлага хүлээлгэж байгаа явдал юм.

Хоёр. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх талаарх зохицуулалт

2.1. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх асуудлыг Үндсэн хуульд тусгасан нь

Засгийн газар парламентын итгэлийг хүлээсэн байх нь үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл төдийгүй парламентын тогтолцооны үндсэн шинж юм. Иймээс Засгийн газар парламентын итгэлийг хүлээсэн

байвал зохино. Итгэл хүлээлгэх буюу үзүүлэх санал (motion of confidence) нь Ерөнхий сайдын санаачилгаар түүнд итгэл хүлээлгэж буйгаа албан ёсоор илэрхийлэхийг парламентаас хүсэхэд хэрэглэх журам юм. Энэ нь тодорхой бодлогын шийдлийг Засгийн газрын оршин тогтнох тухай санал хураалтаар хамтад нь шийдвэрлүүлэх боломжийг Ерөнхий сайдад олгодог. Парламентын тогтолцоотой улсад итгэл хүлээлгэх санал нь Засгийн газар бүрэн эрхээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд хангалттай олонхын дэмжлэгтэй эсэхийг баталгаажуулахад чиглэдэг. Засгийн газрыг дэмжиж буй парламентын олонх хямралд орсон үед үүнийг заримдаа ашигладаг бөгөөд итгэл хүлээлгэх санал нь Засгийн газарт итгэл хүлээлгэж түүнийг дэмжих, эсхүл түүнийг огцруулсны үр дагавартай нүүр тулах хоёрын аль нэгийг парламентын гишүүд сонгохоос аргагүй нөхцөлийг бүрдүүлдэг (Венецийн комисс, CDL-AD(2024)016, догол 13). Ерөнхий сайдад итгэл хүлээлгэвэл Засгийн газар үргэлжлүүлэн ажиллаж, дэмжүүлсэн бодлогоо хэрэгжүүлнэ. Харин итгэл хүлээлгээгүй бол Ерөнхий сайд, Засгийн газар огцорч, шинэ Ерөнхий сайдыг томилох, эсхүл парламент тарах үр дагавартай тул Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэх асуудлыг парламентад тавих нь Засгийн газар, парламент хоорондын харилцан хяналт, тэнцлийн нэг хөшүүрэг юм.

1992 оны Үндсэн хуулийн уг эхэд Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх асуудлыг ерөнхий зохицуулсан байсан. Тодруулбал, Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлд “Өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч Засгийн газар тогтоолын төсөл оруулбал Улсын Их Хурал уул асуудлыг дөчин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэнэ.” гэж, Дөчин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан болон Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэж туссан байжээ. Эдгээр зохицуулалтад Засгийн газар өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсэж холбогдох тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулах, Улсын Их Хурал түүнийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шийдвэрлэхээр ерөнхий заасан байсан. Засгийн газарт итгэл хүлээлгээгүй тохиолдолд Засгийн газар огцрох ч дараагийн Ерөнхий сайдыг томилох хугацаа, томилоогүй бол үүсэх үр дагавар зэргийг Үндсэн хуульд тухайлан заагаагүй байжээ. Тодруулбал, “Ерөнхий сайдын зүгээс өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг Улсын Их Хурлаас хүссэний үр дагавар нь тодорхойгүй, уг асуудалд Улсын Их Хурлын зүгээс хариуцлагатай хандах механизм дутмаг” байсан учраас 1992-2019 онд Ерөнхий сайдын зүгээс ийм тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулж байгаагүй ажээ (Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, 2019, х. 3; Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар, 2019, х. 95).



Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийг “Улсын Их Хурал тогтоолыг баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.” гэж тус тус өөрчлөн найруулсан байна. “Ингэснээр Ерөнхий сайд нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлого, хөтөлбөрөө боловсруулж тууштай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Хэрэв Улсын Их Хурал 30 хоногийн хугацаанд шинэ Ерөнхий сайдыг томилж чадахгүй бол Улсын Их Хурлыг тараах нөхцөл бүрдэх тул гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн харилцан хяналт, тэнцлийг сайжруулах хөшүүрэг болно” гэж үзжээ (Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, 2019, х. 7).

2.2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн тухайд

Улсын Их Хурал 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2020 оны Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчлэн найруулахдаа тус хуулийн 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж заажээ. Түүнчлэн 2023 онд Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, улмаар 2024 онд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинээр батлахдаа тус хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж зохицуулжээ. 2020 оны дээрх хуулийн 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж заасныг 2024 оны тус хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж өөрчилж, “... түүнээс хойш ...” гэсэн хоёр үгийг шинээр нэмжээ.

Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн агуулгыг тайлбарлаж, түүнд 2024 оны Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг нийцсэн эсэхийг шалгахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна:

2.2.1. Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал ...” гэж хэн юуг Улсын Их Хуралд оруулах талаар заасан. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг зөвхөн Ерөнхий сайд өөрөө Улсын Их Хуралд оруулах бөгөөд энэ талаар заавал Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх, эсхүл Засгийн газрын гишүүдтэй зөвлөлдөх шаардлагагүй. Ерөнхий сайдад буюу Засгийн газарт итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулах бүрэн эрхийг бусад байгууллага, албан тушаалтанд Үндсэн хуулиар олгоогүй байна. Тухайлбал, Засгийн газар танхимын зарчмаар ажиллах, Ерөнхий сайд Засгийн газрыг удирдах Үндсэн хуулийн үзэл баримтлалтай учраас Засгийн газрын гишүүн өөртөө, эсхүл Засгийн газарт итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулахыг зөвшөөрөөгүй байна.

Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төсөл нь ерөнхий асуудлаар бус, гагцхүү Улсын Их Хурлын дэмжлэг шаардлагатай, улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар байвал зохино. Тухайлбал, “төсвийн болон бодлогын тодорхой асуудал”-д Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад зааснаар улсын төсөв, түүний орлого бүрдүүлэх, хуваарилах, зарцуулалтын шинжтэй, эсхүл төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэл, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлого, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, байгалийн баялгийг ашиглах төрийн бодлогын зэрэг тодорхой асуудал хамаарна. Засгийн газар нь төсвийн болон бодлогын эдгээр асуудлыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, баталсан шийдвэрийг биелүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхий сайд Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тогтоолын төслийг өргөн мэдүүлэхдээ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, төсөв тэдгээрийн зүйл, хэсэг, заалтын талаарх өөрийн байр суурь болон Улсын Их Хурлаас дэмжлэг хүсэж байгаа асуудлыг тодорхой илэрхийлсэн байна. ...” гэж зохицуулжээ. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан бол ...” гэж Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийг эшилж тусгасан байх тул Ерөнхий сайд улсын төсвийн болон



бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулах агуулга алдагдаагүй байна.

2.2.2.Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор ... шийдвэрлэнэ.” гэж хэлэлцэж эхлэх болон шийдвэрлэх хугацааны хязгаарыг тодорхой заасан нь Улсын Их Хурлын гишүүд уг тогтоолын төслийг судалж, бэлтгэл хангах, нухацтай хэлэлцэх, боломжит хугацаанд шийдвэрлэхэд төдийгүй иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахад чиглэсэн байна. Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулснаас хойш 3 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ. Ийнхүү хэлэлцэж эхлэх хугацааг тогтоосон нь тус хугацаанд Улсын Их Хурлын гишүүн уг тогтоолын төсөлтэй тэгш эрхтэйгээр танилцах, судлах, асуулт, саналаа боловсруулах боломж олгох зорилготой тул уг тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулсан даруйд Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлэх учиртай. Түүнчлэн Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулснаас хойш 10 хоногийн дотор шийдвэрлэхээр заажээ. Өөрөөр хэлбэл, уг тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулснаас хойш Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэх, ийнхүү хэлэлцэж эхэлснээс хойш 7 хоногийн дотор шийдвэрлэх утгатай байна. Тодруулбал, Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хурал хэлэлцэх дээд хугацаа нь 7 хоног байна.

Улсын Их Хурал Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх эсэх асуудлыг хэлэлцэх журмыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэх зэргээр зохицуулсан байна. Үндсэн хуулийн бичвэрт Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулснаас хойш “... гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэж илт тодорхой заасан хугацааг уг зохицуулалтаар “... 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэж 4 хоногоор уртасгажээ. Түүнчлэн уг тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулснаас хойш “... арав хоногийн дотор ... шийдвэрлэнэ.” гэж Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт илт тодорхой заасан хугацааг маргаан бүхий зохицуулалтаар “... 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш 10 хоногийн дотор ...” шийдвэрлэхээр өөрчилсөн байна. Энэ нь уг тогтоолын төслийг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэх, ийнхүү хэлэлцэж эхэлснээс хойш 10 хоногийн дотор шийдвэрлэхээр ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, уг тогтоолын төслийг оруулснаас хойш нийт 10 хоногийн дотор бус, харин 17 хоногийн дотор шийдвэрлэхээр өөрчилжээ. Иймд маргаан бүхий зохицуулалтаар Улсын

Их Хурал Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг хэлэлцэж эхлэх 3 хоногийг 7 хоног болгосон төдийгүй ийнхүү хэлэлцэж эхэлснээс хойш шийдвэрлэх дээд хугацаа 7 хоног байхаар заасныг 10 хоног болгон уртасгасан байх тул Үндсэн хуулийн дээрх заалтыг ноцтой зөрчсөн байна.

Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан даруйд тухайн тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлэхийг үүрэгжүүлсэн зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгаагүй байгаа нь Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн ..." гэх шаардлага зөрчигдөх нөхцөлийг бий болгохоор байна. Түүнчлэн улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр удаашралгүй хэлэлцэж шийдвэрлэх талаар тусгайлан хуульчлаагүй байгаа нь уг тогтоолын төслийг 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэх Үндсэн хуулийн шаардлага зөрчигдөх эрсдэл үүсгэсэн байна.

Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Байнгын хороонд оруулах нь Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу түүнийг Улсын Их Хуралд оруулснаас хойш 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэх хугацааг зөрчих эрсдэлийг нэмэгдүүлэхээр байна. Түүнчлэн парламентын болон хагас ерөнхийлөгчийн тогтолцоотой улсад Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Байнгын хороогоор хэлэлцүүлэхгүйгээр парламентын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэдэг байна. Учир нь Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх нь хууль тогтоох үйл ажиллагаанд хамаарахгүй, харин хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын хяналт, тэнцлийг хангахад чиглэдэг. Иймээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсэгт "Холбогдох Байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна." гэж зайлшгүй зохицуулах шаардлагатай эсэхийг нягталж, уг зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй байна.

2.2.3. Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Ерөнхий сайд ... өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал ..." тухайн тогтоолын төслийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар шийдвэрлэхээр заасан байна. "Улсын Их Хурлын шийдвэр гаргах журмыг тусгайлан зохицуулсан Үндсэн хуулийн заалтыг эерэг утгаар ойлгож санал хураана. Тухайлбал, ... "Ерөнхий сайдын итгэл хүлээлгэх тогтоолын төсөл батлахыг дэмжих" гэсэн томъёоллоор санал хураах

нь Үндсэн хуульд илүү нийцэхээр байна” (Цэцийн дүгнэлт, 2025, №08). Иймд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж (Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэг), Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг батлахыг дэмжих агуулгаар санал хурааж, нийт гишүүний олонхоор буюу туйлын олонхоор батлахаар байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “Ерөнхий сайд ... өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан бол Улсын Их Хурал уг асуудлыг ... шийдвэрлэнэ.” гэж заажээ. Тус хэсгийн “уг асуудал” гэдэгт юуг хамааруулан ойлгох нь бүрхэг байх тул үүнийг Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг батлахыг дэмжих агуулгаар санал хураахаас өөрөөр ойлгох эрсдэл үүсгэсэн байна. “Уг асуудал” гэдгийг Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг эерэг утгаар ойлгож шийдвэрлэхээс илүү өргөн, эсхүл салаа утгаар хэрэглэх боломжтой байх тул эрх зүйн тодорхой байдлыг хангахгүй байна. Иймд тус зүйлийн 102.1 дэх хэсгийн “уг асуудал” гэсэн нь Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг батлахыг дэмжих агуулгаар санал хураах утгыг алдагдуулж, Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт нийцээгүй байна.

2.2.4. Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурал тогтоолыг баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.” гэж шийдвэрийн үр дагаврыг зохицуулсан байна. Энэ агуулгыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 102.1-д заасан тогтоолын төслийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолын төслийг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, энэ тухай тогтоол баталсанд тооцно.” гэж тусгажээ.

Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төсөл Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын дэмжлэг аваагүй бол батлагдахгүй бөгөөд Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, түүнээс хойш 30 хоногийн дотор шинэ Ерөнхий сайдыг Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу томилно (Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг). Энэ хугацаанд Улсын Их Хурал шинэ Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана (Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсэг).

2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийг өөрчлөн найруулсны дараа 2025 оны

5 дугаар сарын 28-ны өдөр Ерөнхий сайдаас “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо уг тогтоолын төслийг 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдөр хэлэлцэж, 17 гишүүн буюу 73.9 хувийн саналаар дэмжсэн байна. Мөн өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах эсэх асуудлаар нууц санал хураалт явуулж, санал хураалтад 82 гишүүн оролцож, 44 гишүүн дэмжиж, 38 гишүүн дэмжээгүйгээс нийт гишүүний олонхын буюу 64-өөс доошгүй тооны гишүүний дэмжлэгийг аваагүй тул уг тогтоолын төслийг батлаагүй байна (Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, 2025.06.02, х.188-189).

Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх буюу 64-өөс доошгүй тооны гишүүн дэмжсэн бол уг тогтоолыг баталсанд тооцно. Улсын Их Хурал уг тогтоолыг баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно (Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг). Иймд Улсын Их Хурал Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг баталснаар ийнхүү итгэл үзүүлсэн гэж үзэхээс гадна уг тогтоолын төсөлд тусгасан улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлыг мөн дэмжсэнд тооцох үр дагавартайгаараа онцлог байна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.7 дахь хэсэгт “Ерөнхий сайдад итгэл үзүүлэх тогтоолыг баталсантай холбогдуулан шаардлагатай бол уг тогтоолд нийцүүлэн зохих хууль, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурал энэ хуульд заасан журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэж заасан байна.

Нэгтгэн дүгнэвэл

1.Үндсэн хуулиар ард түмнээс сонгогдсон Улсын Их Хурал нь Ерөнхий сайдыг томилж замаар Засгийн газрыг эмхлэн байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Засгийн газар нь Улсын Их Хурлын өмнө хариуцлага хүлээж, түүний олонхын итгэл дээр тулгуурлан орших учраас уг итгэлийг алдвал огцрох ч үүнд Улсын Их Хурал хариуцлагатай хандах зохицуулалтыг Үндсэн хуульд тусгасан байна. Засгийн газар Улсын Их Хурлын өмнө хариуцлага хүлээх хамгийн эцсийн, хүчтэй хэлбэр нь Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн санаачилгаар Ерөнхий сайдыг огцруулах эсэхийг шийдвэрлэх санал хураалт юм. Түүнчлэн Ерөнхий сайдын зүгээс өөрт нь итгэл хүлээлгэж буйгаа албан ёсоор илэрхийлэхийг Улсын Их Хурлаас хүсэж, төсвийн болон бодлогын тодорхой асуудлын



шийдлийг Засгийн газрын оршин тогтнох эсэх санал хураалтаар хамтад нь шийдвэрлүүлэх боломжтой. Улсын Их Хурлын нийт гишүүний олонх Ерөнхий сайдыг огцруулахыг буюу Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжсэн, эсхүл Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг батлаагүй бол Ерөнхий сайд, Засгийн газар огцорно. Ийнхүү огцруулснаас хойш 30 хоногийн дотор шинэ Ерөнхий сайдыг томилоогүй бол Улсын Их Хурлыг тараах шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана. Иймээс Улсын Их Хурлын санаачилгаар Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг, эсхүл Ерөнхий сайдын санаачилгаар түүнд итгэл хүлээлгэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэх нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэл хоорондын харилцан хяналт, тэнцлийн чухал хөшүүрэг мөн.

2.Засгийн газрын бие даасан, тогтвортой, хариуцлагатай байдлыг хангах, танхимын зарчмыг бэхжүүлэх зорилгоор Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.” гэж 2019 онд өөрчлөн найруулжээ. Гэтэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “Гишүүд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж зохицуулж, Үндсэн хуулийн тус хэсгийг зөрчсөн байна. Энэ зохицуулалтын “гишүүд” гэдэг нь “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй” гэж шууд ойлгогдохгүй байх төдийгүй Үндсэн хуулийн бичвэрт “... гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэж илт тодорхой заасан хугацааг “... 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэж 4 хоногоор уртасгаж, улмаар Улсын Их Хурал Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэн шийдвэрлэх 7 хоногийг 3 хоног болгон богиносгосон байна. Түүнчлэн маргаан бүхий зохицуулалтад “уг асуудал” гэж бүрхэг заасан нь Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлахыг дэмжих агуулгаар санал хураах Үндсэн хуулийн утгыг алдагдуулах эрсдэлтэй байна.

3.Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.” гэж 2019 онд өөрчлөн найруулсан байна. Гэвч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж заасан нь Үндсэн хуулийн тус хэсгийг зөрчсөн байна. Учир нь Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулснаас хойш “... гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэж Үндсэн хуулийн бичвэрт илт тодорхой заасан хугацааг “... 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэж 4 хоногоор уртасгажээ. Түүнчлэн уг тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулснаас хойш “... арав хоногийн дотор ...” шийдвэрлэхээр Үндсэн хуулийн бичвэрт илт тодорхой заасан хугацааг “... 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш 10 хоногийн дотор ...” гэж уртасгасан тул уг тогтоолын төслийг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэх, ийнхүү хэлэлцэж эхэлснээс хойш 10 хоногийн дотор (нийт 17 хоногийн дотор) шийдвэрлэхээр ойлгогдож байна. Мөн маргаан бүхий зохицуулалтад “уг асуудал” гэж бүрхэг заасан нь Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг батлахыг дэмжих агуулгаар санал хураах Үндсэн хуулийн утгыг алдагдуулах эрсдэлтэй байна.

4.Ерөнхий сайдыг огцруулах, эсхүл түүнд итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 3-10 хоногт хэлэлцэж шийдвэрлэхээр Үндсэн хуульд заасан байна. Иймээс эдгээр тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн даруйд гишүүдэд хүргүүлэх, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр энэ хугацааны дотор удаашралгүй, шууд хэлэлцэж шийдвэрлэх зэрэг нарийвчилсан зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгах шаардлагатай байна. Түүнчлэн Ерөнхий сайдыг огцруулах тухай санал Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлбэртэй байх, уг тогтоолын төслийг батлахыг дэмжих агуулгаар санал хураахаар тодорхой хуульчилбал зохино. Мөн Ерөнхий сайдыг огцруулах, эсхүл түүнд итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороогоор хэлэлцүүлэх зайлшгүй шаардлагатай эсэхийг нягталж, холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй байна.

5.Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн бөгөөд түүний агуулга нь ардчилсан, эрх зүйт төрийн үнэт зүйлсийг өргөн хүрээнд хамгаалж, үндсэн хуульт ёсны суурь үзэл баримтлалыг багтаана. Тухайлбал, хууль дээдлэх ёс нь эрх зүйн тодорхой байдлыг хангах, аливаа хууль, эрх зүйн акт Үндсэн хуульд нийцсэн байх зэрэг зарчмыг баримтлахыг шаардана (Цэцийн тогтоол, 2024, №02). Эрх зүйн тодорхой байдал нь хуулиар юуг зөвшөөрч, хориглох, ямар эрх эдлүүлж, үүрэг хүлээлгэж байгааг мэдэх, хуулийг сахин биелүүлснээр үүсэх үр дагаврыг урьдчилан таамаглах, үүнийхээ үндсэн дээр үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх боломжийг баталгаажуулдаг (Цэцийн дүгнэлт, 2025, №02).

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж заасан нь Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт, тус хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус нийцээгүй төдийгүй эдгээр зохицуулалтад “уг асуудал” гэх ойлгомжгүй нэр томъёо хэрэглэж, эрх зүйн тодорхой байдлыг хангаагүй байх тул хууль дээдлэх ёсыг зөрчсөн байна.

6. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буцаж үйлчлэх хүрээг тодорхойлсон учир энэхүү дүгнэлт нь гарсан цагаасаа хойш (ex nunc) үйлчлэх бөгөөд буцаж үйлчлэхгүй үр дагавартай болохыг тэмдэглэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. ...” гэж заасанд нийцээгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор ... шийдвэрлэнэ.” гэж заасанд нийцээгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэж, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ...” гэж заасныг

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Г.БАЯСГАЛАН

ГИШҮҮД

Д.ГАНГАБААТАР

О.МӨНХСАЙХАН

Ц.ЦОЛМОН

Б.БОЛДБААТАР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2026 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан /даргалагч/, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Ц.Цолмон, Р.Батрагчаа /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд хүсэлт гаргагч Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хандан дараах хүсэлтийг ирүүлжээ:

“Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтад заасан асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах санал гаргасныг Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаж байна.

Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны

тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн энэхүү зохицуулалтын дагуу Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, гагцхүү Үндсэн хуульд захирагдах үүрэг бүхий байгууллага болно. Улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлд Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх маргааныг тусгайлан хуульчилж тодорхойлсон бөгөөд үүнээс бусад асуудлаар шийдвэр гаргах талаар Үндсэн хуульд тусгаагүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэж заасан нь Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуулиар олгоогүй бүрэн эрхийг олгосон буюу шийдвэрлүүлэхээр зохицуулсан, Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байж болзошгүй байна.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг хуульчлахдаа тус зүйлийн 25.7 дахь хэсэгт шүүн таслах ажиллагааны талаарх бүрэн эрхийг тусгайлан тодорхойлсон бөгөөд 25.7.4 дэх заалтад “хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох;” бүрэн эрхийг заажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.” нь Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд хамаарахыг тодорхой заасан бөгөөд уг хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.4 дэх заалтаар Улсын дээд шүүхэд хуулиар харьяаллыг нь

тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох бүрэн эрхийг олгосон Монгол Улсын шүүхийн тухай хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр баталсан бөгөөд сүүлд баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүхэд хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох бүрэн эрхийг олгосонтой холбоотойгоор тухайн харилцааг зохицуулсан хуулиудад давхардал үүссэн байна.

Хуулиудын энэхүү давхардсан зохицуулалт нь хэвээр үйлчилснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино." гэж заасантай тус тус нийцэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэхээр байна.

3.Уг зөрчилтэй зохицуулалтын улмаас Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэцээс нэр бүхий иргэний гаргасан гомдлоор Улсын Их Хурлыг хариуцагчаар татсан эрх зүйн маргаанд хэргийн харьяалал тогтоох асуудлаар ялгаатай шийдвэр гаргаж, хууль хэрэглээний ойлгомжгүй байдал үүссэн жишээг дурдаж болно.

Тодруулбал, "Монгол Улсын Ерөнхий аудиторыг чөлөөлөх тухай" Улсын Их Хурлын 2019 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2007 он)-ийн 45 дугаар зүйлд заасан Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдах албан тушаалтныг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журмын дагуу холбогдох Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад заасны дагуу онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд, хуулиар эрх олгогдсоны дагуу шийдвэрлэсэн болно.

Гэтэл уг асуудлаар нэр бүхий иргэнээс гомдол гаргахад иргэний болон захиргааны хэргийн шүүх маргаан үүсгэхээс татгалзсан ба Үндсэн хуулийн цэц 2023 оны 01 дүгээр магадлалдаа "... эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын дээд шүүх эцэслэн шийдвэрлэх үндэслэлтэй ..." гэж дурдсан бол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 09 дүгээр тогтоолд "... ердийн шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг хэрэглэх замаар шийдвэрлэх "эрх зүйн

маргаан” гэж үзэхээргүй байх тул Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.4 дэх заалтад заасан нөхцөл үүсээгүй, “хэргийн харьяалал тогтоох” үндэслэлгүй байна ...” гэж үзэж хэргийн харьяалал тогтоохоос татгалзсан байна. Үүний дараа Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 10 дугаар магадлалаар уг маргааныг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд харьяалуулан шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн байна.

Дээр дурдсан хуулиудын давхардал, хийдэл нь хууль хэрэглээнд ойлгомжгүй байдал үүсгэж байгаа тул зөрчлийг арилгах зайлшгүй шаардлагатай байна.

Иймд Улсын Их Хурлаас 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна: 1/хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; 2/ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; 3/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх; 4/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй байх тул дээрх маргааныг хянан шийдвэрлэж өгөхийг хүсье.” гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, П.Сайнзориг нар Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хянан шийдвэрлэх маргааны хүрээ, хязгаарыг тодорхойлсон бөгөөд үүнээс бусад ердийн шүүхээр шийдвэрлэгдэх эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоож, холбогдох шүүхэд шилжүүлэх талаар Монгол Улсын Үндсэн хуульд тусгаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасан нь Үндсэн хуулиар гол тулгуур асуудал, зарчмыг тодорхойлсон хэм хэмжээнд нийцүүлэн органик болон бусад хуулиар нарийвчлан зохицуулах эрхийг хууль тогтоох дээд байгууллагад Үндсэн хуулиар шилжүүлсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын шүүхийн тухай хуулийг шинэчлэн найруулахдаа 25 дугаар зүйлийн 25.7.4 дэх заалтад “хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох;” гэж заасан. Шүүхийн хэргийн харьяалал тогтоох зохицуулалтыг түүхчлэн судлан үзэхэд 1993, 2002, 2012 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиудаар энэ харилцааг зохицуулж ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлаас баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хуулиудад давхардсан зохицуулалтын улмаас хууль хэрэглээний нэгдмэл байдал хангагдахгүй, ойлгомжгүй байдал үүсгэж байгаа тул зөрчлийг арилгах зайлшгүй шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан

тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасныг зөрчсөн гэх үндэслэлтэй байх тул дээрх маргааныг хянан шийдвэрлэж өгөхийг хүсье.” гэжээ.

Гурав. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд бэлтгэх хүрээнд дараах баримт бичиг, шийдвэр, судалгаа, эх сурвалжтай танилцаж, холбогдох эрх бүхий этгээдээс тайлбар, лавлагаа гаргуулан авсан болно:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн холбогдох шийдвэр (Цэцийн магадлал, дүгнэлт, тогтоол, Цэцийн гишүүний тогтоол);

Монгол Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн холбогдох шийдвэр;

Монгол Улсын Их Хурлын хүсэлт, 2025.05.08, УИХ-01/5848;

Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хүсэлтийг хэлэлцсэн Хууль зүйн байнгын хорооны 2025.04.09, 2025.04.15, 2025.04.16-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, санал дүгнэлт, Улсын Их Хурлын 2025.04.18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл;

Монгол Улсын Их Хурлаас 2024.05.16-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуультай хамт баталсан Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг хэлэлцсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024.04.14, 2024.04.24, 2024.05.01-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, Улсын Их Хурлын 2024.04.11, 2024.04.25, 2024.05.02, 2024.05.16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл;

Монгол Улсын Их Хурлаас 2021.01.15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, холбогдох судалгаа болон хуулийн төслийг хэлэлцсэн Хууль зүйн байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл;

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурал (Ардын Их Хурал)-аар уг төслийн Жаран дөрөв, Жаран зургадугаар зүйлд холбогдох хэсгийг хэлэлцсэн хуралдааны тэмдэглэл, холбогдох судалгаа тайлан;

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурал (Улсын Бага Хурал)-ын хуралдааны протокол, 1991.10.18, Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж III, 2022;

Ардын Их Хурлын хуралдааны протокол, 1991.12.14, 1991.12.16, Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж IX, 2022;

Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их

Хурлын гишүүн Х.Тэмүүжин, П.Сайнзориг нарын “Тайлбар хүргүүлэх тухай” албан бичиг, 2025.07.03, УИХ-03/8397;

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, “Хуулбар хүргүүлэх тухай” албан бичиг, 2025.06.03, №ТГ-02/675;

Монгол Улсын дээд шүүх, “Тайлбар хүргүүлэх тухай” албан бичиг, 2025.06.25, №04/2166;

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар, “Хариу хүргүүлэх тухай” албан бичиг, хавсралтын хамт, 2025.06.20, №05/2114;

Венецийн комисс, Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгааны эмхэтгэл, CDL-PI(2020)004; Хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн шинэчилсэн тайлан, CDL-AD(2021)001; Хууль дээдлэх зарчмын шалгуур үзүүлэлтийн шинэчилсэн найруулга (The Updated Rule of Law Checklist), CDL-AD(2025)002; Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төслийн дүгнэлт, CDL-AD(2025)022;

Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын Судалгааны төв, “Гадаадын зарим орны Парламент болон Засгийн газраас Үндсэн хуулийн шүүхэд хандах асуудлаарх эрх зүйн зохицуулалт” түүвэр судалгаа, 2025 он; “Эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох, Парламент Үндсэн хуулийн шүүхэд хандах хэлбэр, онцлог” судалгаа, 2025 он; “Ерөнхийлөгчийн зарлиг болон Засгийн газрын шийдвэрийг Парламент хүчингүй болгох эрхтэй эсэх талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт” түүвэр судалгаа, 2025 он;

Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс, “Зарим орны Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт” харьцуулсан судалгаа, 2014 он, XVIII боть;

Холбогдох ном сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл, илтгэл, өгүүлэл, судалгааны материал зэрэг.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Үндсэн хууль (цаашид “Үндсэн хууль” гэх)-ийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.” гэж эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Үндсэн хуулийг зөрчсөн тухай хүсэлтийг ирүүлсэн тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (цаашид “Үндсэн хуулийн цэц” гэх) маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа шууд үүсгэж шийдвэрлэхээр зохицуулсан байна. Мөн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Цэцэд хандах эрх бүхий

байгууллага, албан тушаалтнаас гаргасан хүсэлтийг хүлээн авсан Цэцийн гишүүн маргаан шууд үүсгэж шалгана.” гэж заасныг баримтлан 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсын Их Хурал (цаашид “Улсын Их Хурал” гэх)-аас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хүсэлтээр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудлаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн болно.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй нийцсэн эсэхийг шалгахад дараах үндэслэл тогтоогдож байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Үндсэн хуульд нийцээгүй тухай

3.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.” гэсэн заалтын агуулгыг хэт өргөжүүлж, Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулсан байна.

4.Үндсэн хуулийн заалтыг тайлбарлахдаа бичвэрийн үгийн шууд утгыг ашиглахаас гадна тухайн заалтын зорилгод нийцсэн байдлаар утгажуулах шаардлагатай (Цэцийн дүгнэлт, 2025.10.22, №08). Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэц өөрийн санаачилгаар хянан шийдвэрлэнэ гэсэн нь иргэн өөрийн Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөө (цаашид “үндсэн эрх” гэх) нь зөрчигдсөн тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргахаар, мөн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргах агуулгыг илэрхийлжээ. Харин

иргэдийн гаргасан өргөдөл, мэдээллийн дагуу Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргаан үүсгэх эсэхийг Үндсэн хуулийн цэц зөвхөн өөрийн санаачилгаар шийдвэрлэхээр байна. Түүнчлэн Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ гэсэн нь дээрх эрх бүхий байгууллага, албан тушаалтан Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргасан тохиолдолд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа шууд үүсгэн хянан шийдвэрлэхээс өөрөөр бусад байгууллага, албан тушаалтан Үндсэн хуулийн цэцэд хандах эрхийг багтаагаагүй болохыг Үндсэн хуулийн бичвэрийн үгийн шууд утгаар ойлгохоор байна. Гэтэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах эрх бүхий эдгээр субъектээс гадна төрийн бусад байгууллага, албан тушаалтан, олон нийтийн байгууллага аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор гомдол гаргахыг зөвшөөрч нэмсэн нь Үндсэн хуулийн цэцэд хандах субьектийг хэт өргөжүүлсэн байна.

5.Маргаан бүхий зохицуулалт нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргааныг мөн өргөтгөсөн байна. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэц зөвхөн Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх учиртай. Гэтэл Үндсэн хуулийн цэц аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоохоор заасан нь зөвхөн Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар бус, бусад хуулиар тодорхойлсон хэргийн харьяалал (нутаг дэвсгэрийн харьяалал, эсхүл шүүхийн харьяалал)-ыг шийдвэрлэх өргөн агуулгатай байна. Тухайлбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт иргэний хэргийн харьяаллыг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт захиргааны хэргийн харьяаллыг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт эрүүгийн хэргийн харьяаллыг тус тус хуульчилж, холбогдох шүүх нь шийдвэрлэхээр тогтоосон байна.

6.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох асуудлыг нарийвчлан зохицуулаагүй тул Монгол Улсын дээд шүүх (цаашид “Улсын дээд шүүх” гэх)-ийн энэ талаарх бүрэн эрхтэй давхцал үүсгэхээр байна. Тодруулбал, 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэгт “Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд тус зүйлийн 25.7.4 дэх заалтад “хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох;” гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Улсын дээд шүүхийн танхим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журамд нийцүүлэн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”

гээд тус зүйлийн 28.1.1 дэх заалтад “хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллыг тогтоох;” гэж тус тус заасан байна. Үүнээс үзвэл аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох болон хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох зохицуулалт ямар ялгаатай болох нь тодорхойгүй байна. Улсын дээд шүүх хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох хүрээнд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох боломжтой байх бөгөөд ийнхүү харьяалал тогтоогоогүй нь иргэний үндсэн эрхийг зөрчсөн тухай өргөдөл ирүүлснээс бусад тохиолдолд Үндсэн хуулийн цэц уг асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхгүй.

7.Улсын дээд шүүхэд 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдөр хүртэлх хугацаанд “хэргийн харьяалал тогтоолох” асуудлаар 20 иргэнээс өргөдөл, хүсэлт ирүүлснээс 7 хэргийн харьяаллыг тогтоож шийдвэрлэсэн байна (Улсын дээд шүүхийн Тамгын газар, 2025.06.23, №05/2141). Тухайлбал, нэр бүхий иргэнээс Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэст холбогдуулан гаргасан эцэг тогтоосон бүртгэлийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагатай хэргийн харьяалал тогтоолох хүсэлт гаргасны дагуу 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 156 дугаар тогтоолоор захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан болохыг тогтоож шийдвэрлэсэн байна.

8.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “... холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэж заасан нь Үндсэн хуулийн цэцээс шүүхтэй харилцах харилцааг хэт өргөжүүлсэн байх тул Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байна. Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд тус хэсгийн 3 дахь заалтад “хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;” гэж Үндсэн хуулийн цэцээс үндсэн эрхийг хамгаалах талаарх асуудлыг Улсын дээд шүүхэд шилжүүлэн хянан шийдвэрлүүлэхийг Үндсэн хуулиар зөвшөөрсөн байна. Харин Улсын дээд шүүхээс бусад шүүх (анхан болон давж заалдах шатны шүүх)-д үндсэн эрхийг хамгаалах талаарх асуудлыг шууд шилжүүлэн шийдвэрлүүлэх бүрэн эрхийг Үндсэн хуулийн цэцэд олгоогүй байхад маргаан бүхий зохицуулалтаар бусад шүүхэд шилжүүлж болохоор хуульчилсан нь Үндсэн хуульд нийцэхгүй байна.

9.Үндсэн хуулийн цэц эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох асуудлыг маргаан бүхий хуулийн хэт ерөнхий зохицуулалтын



дагуу шийдвэрлэх үндэслэлгүй байна. Харин эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтооходтой холбоотой үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуульд нийцүүлэн иргэний өргөдлийн дагуу хянан шийдвэрлэх боломжтой. Тодруулбал, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлээр зохицуулсан аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох хүрээнд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "... шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ..." үндсэн эрхийг хамгаалах асуудлыг хянан шийдвэрлэж байсныг Үндсэн хуулийн цэцийн дараах шийдвэрээс харж болно. Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дунд суудлын хуралдаанаас гаргасан 07 дугаар магадлалаар иргэн Ц.Алтанцолын гаргасан гомдлын дагуу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийг үндэслэн "Иргэн Ц.Алтанцол нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээлгэх, учирсан гэм хорыг арилгуулахаар Нийслэлийн шүүх, Ардын эрх сонины газартай холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг Улсын дээд шүүхээр харьяалуулан шийдвэрлүүлэхээр тогтоосугай." гэж шийдвэрлэсэн байна. Энэ магадлалд "Иргэн Ц.Алтанцолын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээлгэхээр гаргасан гомдолтой эрх зүйн маргааныг Улсын дээд шүүх, Нийслэлийн шүүх, Баянзүрх дүүргийн шүүх 1997 оны 02 дугаар сарын 06-аас одоо хүртэл шийдвэрлэж өгөөгүй болох нь нотлох баримтуудаар тогтоогдож байна" гэж дүгнэснээс үзвэл уг хэргийн харьяаллыг тогтоох замаар тухайн иргэний шүүхэд гомдол гаргах эрхийг хамгаалсан байх төдийгүй уг асуудлыг Улсын дээд шүүхэд шилжүүлж Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг агуулгаар нь хэрэглэсэн байна. Түүнчлэн, Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн дунд суудлын хуралдаанаас гаргасан 11 дүгээр магадлалаар "Иргэн Б.Отгонтуяа, С.Аюушжав, Л.Ганзориг, Д.Эрдэнэчимэг нарын 12 шүүгчийг албан тушаалд буцаан томилоогүйтэй холбогдуулан эрх нь зөрчигдсөн тухай маргааныг Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд анхан шатны журмаар харьяалуулан шийдвэрлүүлэхээр тогтоосугай." гэж шийдвэрлэжээ. Энэхүү магадлалд "нэр бүхий иргэдийг шүүгчийн албан тушаалд буцаан томилоогүй тул зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар Үндсэн хуулийн цэц, иргэний болон захиргааны хэргийн давж заалдах, анхан шатны шүүхэд хандан өргөдөл, нэхэмжлэл, гомдол удаа дараа гаргасан боловч харьяаллын бус гэсэн үндэслэлээр хэрэг, маргаан үүсгэхээс татгалзсан ..." нь хэргийн харьяаллыг ийнхүү тогтоох үндэслэл болсон талаар тэмдэглэсэн байх тул энэ нь иргэний шүүхэд гомдол гаргах үндсэн эрхийг хамгаалахад чиглэсэн байна. Уг магадлалд Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг удирдлага болгосон нь Үндсэн хуулийн тус зохицуулалтын хүрээнд шүүх хуулийг хэрэглэхдээ шүүхэд гомдол гаргах зэрэг үндсэн эрхийг зөрчсөн асуудлыг хянан шийдвэрлэх агуулгатайг харуулж байна.

10. Дээрхээс үзэхэд, эрх зүйн маргааныг аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаагаас иргэний Үндсэн хуулиар хамгаалсан үндсэн эрх зөрчигдсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж, шаардлагатай тохиолдолд тухайн маргааны хэргийн харьяаллыг тогтоохоор байна. Өөрөөр хэлбэл, эрх зүйн маргаан аль шүүхийн харьяалалтай нь Монгол Улсын шүүхийн тухай болон бусад хуульд заасны дагуу Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд хамаарах бол уг маргааныг аль ч шүүх авч хэлэлцээгүйн улмаас иргэний үндсэн эрх зөрчигдсөн тухай өргөдлийг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ. Ингэхдээ иргэний өргөдлийн дагуу үндсэн эрхийн маргаан хянан шийдвэрлэх замаар буюу эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн иргэн холбогдох шүүхэд, дараа нь Улсын дээд шүүхэд хандах зэргээр хуульд заасан бүхий л арга замыг дуусгасны дараа (субсидиар зарчмыг хангаж) эрх зүйн маргааныг аль ч шүүх авч хэлэлцээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх учиртай. Энэ нь хэргийн харьяаллыг тогтоох Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг үгүйсгээгүй, харин шүүх эрх мэдлийн байгууллагын шийдвэрийн улмаас иргэний үндсэн эрх зөрчигдөхгүй байх, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх замаар Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх болон бусад эрхийн баталгааг хангах хяналтыг хэрэгжүүлж байгаа юм. Улсын дээд шүүхээс ирүүлсэн тайлбарт Үндсэн хуулийн цэц эрх зүйн маргааныг аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаагаас иргэний үндсэн эрх зөрчигдсөн эсэхийг хянан шийдвэрлэх нь “Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөний хамгаалал ба иргэн, хуулийн этгээдийн шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгааг хадгалж байна” гэжээ (Монгол Улсын дээд шүүх, 2025.06.25, №04/2166). Иймд Үндсэн хуулийн цэцээс иргэний өргөдлийг Дунд суудлын хуралдаанаараа хянан шийдвэрлэж, эрх зүйн маргааныг аль ч шүүх авч хэлэлцээгүй нь үндсэн эрхийг зөрчсөн гэж үзвэл Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын дагуу Улсын дээд шүүхэд шилжүүлж шийдвэрлэхээр байна.

11. Үндсэн хууль нь ард түмний дээд эрх мэдлийг илэрхийлж, тэдний эрхэм зорилгыг агуулдаг тул эрэмбийн хувьд Монгол Улсад заавал биелэх, дээд хүчин чадалтай суурь хууль мөн. Энэ агуулгыг Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж тусгасан байна. Төрийн аливаа байгууллага, албан тушаалтны шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байхаар ийнхүү заасан нь үндсэн хуульт ёсыг хэрэгжүүлэх нөхцөл юм. Үндсэн хуулийн цэц бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх замаар Үндсэн хуулийг чандлан сахиулж, энэ нөхцөлийг хангана (Цэцийн тогтоол, 2024, №02).

12. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэхээр өргөн агуулгаар тусгасан байх тул түүний харьяалан шийдвэрлэх маргаан нь зөвхөн мөн зүйлийн 2 дахь хэсэгт тоочин заасан “маргаантай асуудал”-аар хязгаарлагдахгүй бөгөөд Үндсэн хуулийн эдгээр зохицуулалтад “маргаан”, “маргаантай асуудал” гэх ялгаатай агуулга бүхий нэр томъёог хэрэглэсэн байна. Иймээс Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт тоочсон маргаантай асуудал төдийгүй Үндсэн хуулийг зөрчсөн тухай бусад маргааныг хянан шийдвэрлэхээр байна. Түүнчлэн Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж түүний бүрэн эрхийг ерөнхийлөн томъёолжээ. Эндээс үзвэл, Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй бөгөөд эдгээр бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх замаар Үндсэн хуулийг чандлан сахиулна.

13. Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг ...” иргэнийхээ өмнө хариуцах бөгөөд Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны гаргасан аливаа эрх зүйн акт Үндсэн хууль, түүнд заасан үндсэн эрхэд нийцсэн байвал зохино (Цэцийн тогтоол, 2024, №02).

14. Үндсэн хуулийн төслийг хэлэлцсэн Улсын Бага Хурлын болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлээс үзэхэд олон тооны гишүүд нь Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болохын хувьд хууль, төрийн байгууллага, албан тушаалтны бусад шийдвэр, үйл ажиллагаа үндсэн эрхийг зөрчсөн тухай маргааныг тухайн иргэний өргөдлийн дагуу шийдвэрлэх бүрэн эрхтэй гэсэн байр суурийг илэрхийлж байжээ. Түүнчлэн иргэн шүүхэд хандан шийдвэрлүүлэх бүх арга замыг ашиглаж дуусгасан (Улсын дээд шүүхийн шийдвэр гарсан) ч үндсэн эрхээ хамгаалуулж чадаагүй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргаж хянан шийдвэрлүүлэх эрхтэй гэж ойлгож, тодорхой жишээ дээр тайлбарлаж байжээ (Үндсэн хуулийн эх сурвалж III, 2022, х. 228-230, 233-236; Үндсэн хуулийн эх сурвалж IX, 2022, х. 513-514, 632, 664, 688-689, 695-696; Үндсэн хуулийн эх сурвалж X, 2022, х. 419-420, 566-567, 569, 576-577).

15. Үндсэн хууль, түүнд заасан үндсэн эрх нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагын шийдвэрийг хязгаарлах хүчин чадалтай, эдгээр байгууллагын шийдвэр үндсэн эрхийг зөрчөөгүй, зөрчсөн тохиолдолд Үндсэн хуулийн цэц түүнийг нь сэргээж чаддаг байж Үндсэн хууль бүхэлдээ шууд хэрэгждэг эрх зүй болно. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хамаарах аль ч байгууллага, албан тушаалтан Үндсэн хуулийг зөрчихгүй байх ёстой. Тэдгээрийн үйлдэл, эс үйлдэхүй, гаргаж буй шийдвэрийг бүхэлд нь Үндсэн хуульд нийцүүлж хянах бүрэн эрхийг хэрэгжүүлснээр Үндсэн хуулийн цэц бусад улсын үндсэн хуулийн шүүхийн нэгэн адил Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болж бүрэн утгаараа чадах бөгөөд Үндсэн хуулийг ийм агуулгаар тайлбарлах нь зүйтэй байна.

Үндсэн эрхийг хамгаалах асуудлыг хянан шийдвэрлүүлэхээр Улсын дээд шүүхэд шилжүүлэх тухай

16. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт тоочоогүй эрх зүйн акт, тухайлбал хуулийг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбар, тодорхой хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр үндсэн эрх зөрчсөн тухай маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж байжээ. Тодруулбал, Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн дунд суудлын хуралдаанаас гаргасан 08 дугаар дүгнэлтэд “Улсын дээд шүүхийн бүгд хурлын 1993 оны 25 дугаар тогтоолоор баталсан Өмч хувьчлалын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын тайлбарын 3 дахь заалт нь утга агуулгаараа ... Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан иргэдээс зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг бэхжүүлсэн заалттай харшилсан байна. ...” гэж дүгнэж, уг асуудлыг Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Улсын дээд шүүхэд шийдвэрлүүлэхээр шилжүүлжээ.

17. Үндсэн хуулийн цэц шүүх хууль бус бүрэлдэхүүнтэй шийдвэр гаргаснаар иргэний шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрх зөрчигдсөн асуудлыг Улсын дээд шүүхэд шилжүүлж, уг эрхийн зөрчлийг арилгуулсан байна. Тодруулбал, иргэн Т.Ганбатын нэхэмжлэлтэй Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд холбогдох хэргийг анхан болон давж заалдах шатны шүүх 2018 онд тус тус хянан шийдвэрлэснийг 2019 онд хяналтын шатны шүүх хянан үзээд холбогдох шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байна. Ийнхүү уг хэргийг 2020 онд анхан, давж заалдах шатны шүүхээр, 2022 онд хяналтын шатны шүүхээр хэлэлцээд маргааныг дуусгавар болгожээ. Гэвч 2018 онд анхан шатны шүүх хуралдаанаар хэргийг шийдвэрлэхэд бүрэлдэхүүнд нь орсон шүүгч 2022 онд хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэхэд мөн бүрэлдэхүүнд нь дахин орсон байна. Холбогдох шүүгч хэрэг, маргааныг өөр шатны журмаар



хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй буюу дахин оролцож болохгүй тухай журмыг зөрчсөн талаар Шүүхийн сахилгын хорооны шийдвэр гарсан ч Улсын дээд шүүх хэргийг дахин хянахаас татгалзсан байна. Иймээс энэ талаар иргэн Т.Ганбат Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргасныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн хянаад 2024 оны 2/168 дугаар албан бичгээр “Шүүх хууль бус бүрэлдэхүүнтэй шийдвэр гаргах нь иргэний шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрхийг илтэд зөрчих үр дагавартай” гэж үзэж, Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн уг эрхийг хамгаалах асуудлыг хянан шийдвэрлүүлэхээр Улсын дээд шүүхэд шилжүүлсэн байна. Улмаар Улсын дээд шүүх энэхүү албан бичгийн дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.5 дахь заалтыг удирдлага болгон нийт шүүгчийн хуралдаан хийж, 2024 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 20 дугаар тогтоолыг гарган Т.Ганбатын өргөдөлд дурдсан асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлүүлэхээр Иргэний хэргийн танхимд шилжүүлсэн байна. Улмаар Улсын дээд шүүхийн 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 001/ШТ2024/00029 дүгээр тогтоолоор тухайн хэргийг урьд нь хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 001/ХТ2022/00839 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр дахин хуваарилсан байх бөгөөд уг хэргийг Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, тогтоол гаргажээ (2024.06.18, №001/ХТ2024/00148).

18.Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт тоочсон хууль, бусад шийдвэр, албан тушаалтны үйл ажиллагааны талаарх өргөдөл болон Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын хүрээнд багтах шүүхийн шийдвэр, хуулийг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбар үндсэн эрх зөрчсөн тухай өргөдлийг хянан шийдвэрлэх журам нь адил байх боловч гарах шийдвэр, үр дагавар нь ялгаатай. Шүүх хуулийг тайлбарлах, хэрэглэхдээ тухайн өргөдөл гаргасан иргэний үндсэн эрхийг зөрчсөнийг Үндсэн хуулийн цэцийн магадлалаар тогтоосон бол Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын дагуу холбогдох эрхийг хамгаалах асуудлыг Улсын дээд шүүхэд шилжүүлнэ. Улсын дээд шүүх Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.5 дахь заалтад заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаас гаргасан магадлалын дагуу тухайн асуудлыг үндсэн эрхэд нийцүүлэн шийдвэрлэнэ.

19.Үндсэн хууль болон бусад хуульд баталгаажуулсан эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх нь шүүхийн гол зорилт юм. Тиймээс иргэний өргөдлийн дагуу үндсэн эрх нь зөрчигдсөн гэдгийг Үндсэн хуулийн цэц тогтоож, хуулийн дагуу шүүхээр тухайн эрхийг хамгаалуулах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх шаардлагатай гэж үзвэл Улсын

дээд шүүхэд шилжүүлнэ. Улсын дээд шүүх өөрт нь ийнхүү шилжүүлсэн асуудлыг зохих журмын дагуу заавал хянан шийдвэрлэх замаар үндсэн эрхийг хамгаалах үүргээ хэрэгжүүлнэ.

20. Үндсэн хуулийн цэцээс үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэхдээ холбогдох шүүхийн шийдвэрийг хүчингүй болгохгүй, харин үндсэн эрхийг хамгаалах асуудлыг Улсын дээд шүүхэд шилжүүлж хянан шийдвэрлүүлж байгаа учраас энэ нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.” гэж заасантай харшлахгүй. Үндсэн хуулийн цэцийн магадлалаар шүүхийн шийдвэр, хуулийг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбар үндсэн эрх зөрчсөн гэдгийг тогтоовол уул асуудлыг Улсын дээд шүүхэд шилжүүлж өөрөөр нь хянан шийдвэрлүүлэх энэхүү журам нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага ...” гэж заасныг харгалзсан Үндсэн хуулийн хяналтын Монгол загварын үндсэн шинж юм. Түүнчлэн Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулах зохицуулалт нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн ...” гэж заасныг мөн адил харгалзсан хэрэг болно. Үндсэн хуулийн цэц үндсэн эрхийн маргааныг ийнхүү хянан шийдвэрлэх журмыг Монгол Улсын Үндсэн хуулийн дээд байдлыг баталгаажуулж, шүүх эрх мэдлийн институтийн залгамж чанарыг хангаж, шүүх бүрийн Үндсэн хуулиар тогтоосон үйл ажиллагааны бүхэллэг байдлыг хамгаалахад нийцнэ гэж Венецийн комисс үзжээ (CDL-AD(2025)022, догол 146).

21. Үндсэн хуулийн цэц иргэний өргөдлийн дагуу маргааныг хянан шийдвэрлэхдээ өргөдөлд дурдсан эрх зүйн акт (шүүхийн шийдвэр зэрэг) тухайн иргэний үндсэн эрхийг зөрчсөн эсэхийг шалгана. Үндсэн хуулийн цэц зөвхөн Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх тул хууль хэрэглээтэй холбоотой асуудлыг ердийн шүүхэд үлдээж, зөвхөн Үндсэн хуулийн хүрээнд үндсэн эрхийг зөрчсөн эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Энэ талаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж түүнийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан бол мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй.”, 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэцэд ирүүлсэн маргааны шаардлагын зарим нь Цэцэд,

зарим нь өөр шүүх буюу бусад байгууллагад харьяалалтай байвал Цэц зөвхөн өөрийн харьяалалтай маргааны шаардлагыг шийдвэрлээд бусдын харьяалах маргааны шаардлагыг шийдвэрлэхээс татгалзана. Энэ нь тэр маргааныг харьяалах байгууллагаас хянан шийдвэрлэх ажиллагаанд саад болохгүй.” гэж хуульчилсан. Иймд Үндсэн хуулийн цэц нь шүүх хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг хянахгүй бөгөөд шүүхийн мэргэжлийн алдааг засах шат дамжлага биш юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиас бусад хуулийн заалтыг тайлбарлах, хэрэглэх, хэргийн үйл баримтыг тогтоох, үнэлэх асуудлыг харьяалах шүүх нь шийдвэрлэнэ. Харин Үндсэн хуулийн цэц шүүхийн хэрэглэсэн ердийн хуулийг бус, гагцхүү Үндсэн хуулийг хэмжүүр болгоно.

22.Иргэний өргөдлийн дагуу маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэхэд хүлээн авах боломжгүй, давтагдсан, илт үндэслэлгүй гаргасан өргөдлийг тодорхойлох, үндсэн хуулийн шүүхийн ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор эдгээртэй адил шүүлтүүрийг баримталдаг бусад улсын нийтлэг сайн туршлага байгааг тэмдэглэх нь зүйтэй (Венецийн комисс, CDL-AD(2021)001, догол 73-98).

23.Иймд иргэний үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх талаарх Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, тус зүйлийн 2 дахь хэсэг, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн зохицуулалтыг холбож цогцоор нь авч үзвэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасантай нийцээгүй байна.

Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд гаргасан хүсэлтийн тухай

24.Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн талаарх хүсэлт нь Үндсэн хууль мөрдөгдөж эхэлснээс хойших анхны тохиолдол бөгөөд Улсын Их Хурлын хууль тогтоох онцгой бүрэн эрхтэй нь хамааралтайгаараа онцлог байна.

25.Улсын Их Хурал хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэн боломжтой байсан ч Үндсэн хуулийн

цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийг тус хуульд өөрчлөлт оруулах замаар хүчингүй болсонд тооцоогүй байна. Харин Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд гаргасан хүсэлтдээ "... хуулиудын давхардал, хийдэл нь хууль хэрэглээнд ойлгомжгүй байдал үүсгэж байгаа тул зөрчлийг арилгах зайлшгүй шаардлагатай байна." гэж үндэслэлээ тодотгосон байна. Хуулиудын давхардал, хийдлийг арилгах замаар хуулийг боловсронгуй болгох асуудал нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй, хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал болохыг онцлон тэмдэглэж байна.

26. Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц иргэдийн өргөдөл, мэдээлэл, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр хянан шийдвэрлэдэг хэдий ч Улсын Их Хурлаас шийдвэрлэсэн улс төрийн бодлогын асуудал (political question) Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй. Тодруулбал, гадаад харилцаа, үндэсний аюулгүй байдал, улсыг батлан хамгаалах, төрийн санхүү, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлох, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв батлах зэрэг асуудал нь Үндсэн хуулиар хууль тогтоогчид онцгойлон хуваарилсан улс төрийн бодлогын асуудал тул Үндсэн хуулийн маргааны шинжийг агуулдаггүй.

27. Улсын Их Хурлын болон бусад эрх мэдлийн онцгой бүрэн эрхэд хадгалахаар тогтоосон, Үндсэн хуулийн бичвэр, зарчим, үзэл баримтлалд уг маргааныг хянан шийдвэрлэхэд удирдлага болгох эрх зүйн шалгуур тусгагдаагүй, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлаагүй, эрх мэдлээ хэтрүүлээгүй (ultra vires) зарим асуудлыг Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд үл хамаарах улс төрийн бодлогын асуудал гэж үзэх номлолыг Үндсэн хуулийн цэцийн өмнөх олон шийдвэрт баримталсан байна. Энэ нь ард түмний итгэлийг хүлээж сонгогдсон, тэднийг төлөөлж, бодлого боловсруулж, хууль тогтоох үүрэг хүлээсэн хууль тогтоох байгууллагад Үндсэн хуулиар олгосон онцгой бүрэн эрх, сонгогчдын өмнө хүлээсэн хариуцлага, Үндсэн хуульд тусгасан төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг хүндэтгэж буйн илрэл юм (Цэцийн магадлал, 2025.04.30, №14).

28. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар Үндсэн хуулийн цэцэд хандан хуулийн зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн эсэхийг шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргаж байгаа нь дэлхийн ихэнх улсад байдаггүй практик юм. Улсын Их Хурал хамтын шийдвэр гаргадаг төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд



Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэдэг тул хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл энэ талаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах замаар бус, харин Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу өөрөө шийдвэрлэх боломжтой байна. Иймд парламент дахь цөөнхийн хяналтыг сайжруулах үүднээс Улсын Их Хурал чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргахаас гадна, цөөнх буюу тодорхой тооны гишүүн ийм хүсэлт гаргах эрхтэй тул энэ чиглэлээр холбогдох хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

29. Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийг парламент дахь цөөнхөд буюу тодорхой тооны гишүүнд эдлүүлдэг Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (Бундестагийн нийт гишүүний 1/4), Бүгд Найрамдах Франц Улс (парламентын, эсхүл сенатын 60 гишүүн), Бүгд Найрамдах Албани Улс (парламентын нийт гишүүний 1/5), Бүгд Найрамдах Болгар Улс (Үндэсний Ассамблейн нийт гишүүний 1/5) зэрэг ардчилсан тогтолцоотой, эрх зүйт төртэй улсын сайн туршлага байна (Венецийн комисс, CDL-PI(2020)004, х. 45-46). Эдгээр улс хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн шүүхэд хандахад парламентын хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор шийдвэр гаргахыг шаарддаггүй, харин парламент Үндсэн хууль зөрчсөн, эсхүл иргэний үндсэн эрхийг хязгаарласан хууль баталсан гэж үзвэл цөөнх болсон гишүүдийн зүгээс энэ асуудлаар (a posteriori) Үндсэн хуулийн шүүхэд хандахыг зөвшөөрдөг байна.

Бусад асуудал

30. Хууль дээдлэх зарчим (Rule of Law) нь эрх зүйн онолын суурь ойлголтын нэг бөгөөд энэхүү зарчмыг эрх зүйн онолын эрдэмтэд өөр өөрийн өнцгөөс, тухайн улсын онцлогт тохируулан олон янзаар тодорхойлж байсан байна. Тухайлбал, Венецийн комиссын баталсан 2016 оны “Хууль дээдлэх зарчмын шалгуур үзүүлэлт”-д хууль ёс, эрх зүйн тодорхой байдал, эрх мэдлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, хуулийн өмнө эрх тэгш байх болон ялгаварлан гадуурхахгүй байх, шүүхэд хандах, хууль дээдлэх зарчмын тулгамдсан асуудлуудын жишээг хууль дээдлэх зарчмын шалгуур үзүүлэлт болгож байсан бол 2025 оны “Хууль дээдлэх зарчмын шалгуур үзүүлэлтийн шинэчилсэн найруулга”-аар дээрх шалгуур үзүүлэлтийг төрийн эрх мэдлийн харилцан хяналт, тэнцэл, үндсэн хуулийн хяналтаар нэмж баяжуулсан байна (Венецийн комисс, CDL-AD(2025)002). Эдгээр шалгуур үзүүлэлтийг тус комиссын 46 гишүүн болон бусад улс өөрийн ардчилсан тогтолцоог хэмжихэд хэрэглэдэг боловч заавал дагаж мөрдөх үүрэггүй, зөвлөмжийн шинжтэй (soft law) хэдий ч Монгол Улсын хувьд Венецийн комиссоос гаргасан зөвлөмжийг эрх зүйн онолын эх сурвалжаар ашиглаж Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт хэрэглэх боломжтой.

31. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “хууль дээдлэх” тухай ойлголт нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаар илэрхийлэгдсэн боловч агуулга, багтаамжийн хувьд ардчилсан, эрх зүйт төрийн үнэт зүйлсийг өргөн агуулгаар хамгаалж, үндсэн хуульт ёс болон хууль дээдлэх ёсны суурь үзэл баримтлалыг өөртөө багтаана (Цэцийн дүгнэлт, 2025, №02) гэж Үндсэн хуулийн цэцийн олон шийдвэрт тусгалаа олжээ. Эдгээрээс үзэхэд, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “хууль дээдлэх зарчим”-ыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байх бөгөөд харин ч иргэний шүүхэд хандах буюу гомдол гаргах эрхийг илүү баталгаажуулсан зохицуулалт болжээ.

32. Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрхийг баталгаажуулсан байна. Түүнчлэн Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:” гэсэн бөгөөд маргаан бүхий заалтаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргадаггүй, харин Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд магадлал гаргаж холбогдох шүүхэд шилжүүлдэг тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийцээгүй гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд



захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасанд нийцээгүй байна.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийцсэн байна.

3.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Г.БАЯСГАЛАН

ГИШҮҮД

Д.ГАНГАБААТАР

О.МӨНХСАЙХАН

Ц.ЦОЛМОН

Р.БАТРАГЧАА



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс (цаашид “Хэлэлцэн тохиролцогч талууд” гэх) хоорондын нийгмийн хамгааллын салбар дахь харилцааг зохицуулах зорилгоор дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

I БҮЛЭГ ЕРӨНХИЙ ЗААЛТ

1 дүгээр зүйл Нэр томьёо

1. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд:

- а) **“хууль тогтоомж”** гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан нийгмийн хамгааллын салбарыг зохицуулдаг хууль болон бусад эрх зүйн актыг ойлгоно;
- б) **“иргэн”** гэж Монгол Улсын тухайд Монгол Улсын иргэн, Бүгд Найрамдах Австри Улсын тухайд Бүгд Найрамдах Австри Улсын иргэнийг ойлгоно;
- в) **“эрх бүхий этгээд”** гэж Монгол Улсын тухайд нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн сайдыг, Бүгд Найрамдах Австри Улсын тухайд Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн зохицуулалтын асуудал эрхэлсэн Холбооны сайд нарыг ойлгоно;
- г) **“эрх бүхий байгууллага”** гэж Монгол Улсын тухайд энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагыг болон Бүгд Найрамдах Австри Улсын тухайд 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийг бүрэн, эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлэх үүрэг бүхий институт, агентлаг, байгууллага, эсхүл холбогдох бусад байгууллагыг ойлгоно;
- д) **“даатгуулсан хугацаа”** гэж Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн, эсхүл даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааг ойлгоно;

- е) “**ТЭТГЭМЖ**” гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн дагуу олгох тэтгэвэр, эсхүл нэмэлт, эсхүл бусад нэмэгдэл мөнгөн тэтгэмжийг ойлгоно.
2. Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн г) заалтад заасан эрх бүхий байгууллагууд өөрчлөгдвөл Хэлэлцээрт өөрчлөлт оруулах шаардлагагүйгээр эрх бүхий этгээдүүд харилцан бичгээр мэдэгдэнэ.
3. Энэхүү Хэлэлцээрт тодорхойлоогүй аливаа нэр томъёог тухайн Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн хууль тогтоомжид заасан утгаар ойлгоно.

2 дугаар зүйл Хамрах хүрээ

1. Энэхүү Хэлэлцээрт дараах хууль тогтоомж хамаарна:
- а) Монгол Улсын тухайд:
Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн асуудлаарх хууль тогтоомж;
Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн асуудлаарх хууль тогтоомж;
- б) Бүгд Найрамдах Австри Улсын тухайд:
Нотариатчидын онцгой хамгааллаас бусад тэтгэврийн даатгалын асуудлаарх хууль тогтоомж;
Зөвхөн II бүлгийн тухайд, өвчний даатгал болон ослын даатгалын асуудлаарх хууль тогтоомж.
2. Энэхүү Хэлэлцээр нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийг шинэчлэн найруулсан, орлуулсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан, дагалдан гарсан, эсхүл багцалсан аливаа хууль тогтоомжид мөн адил хамаарна.

3 дугаар зүйл Хамаарах этгээд

Энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч нэг талын, эсхүл хоёр талын хууль тогтоомжид хамаарч байгаа болон хамаарч байсан, мөн холбогдох хууль тогтоомжийн дагуу тэдгээр хүмүүсээс эрх үүсэж байгаа хүмүүс энэ Хэлэлцээрт хамаарна.

4 дүгээр зүйл Эрх тэгш хандах

1. Энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын иргэд, хамаарал бүхий хүмүүс болон тэжээгчээ алдагчдад Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд энэхүү Хэлэлцэн тохиролцогч талын иргэний адил эрх тэгш хандана.
2. Бүгд Найрамдах Австри Улсын тухайд энэхүү Хэлэлцээрийн зорилгоор энэ зүйлийн 1 дэх хэсэг нь (ЕС) No 883/2004 журам үйлчилдэг улсын иргэд болон Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт оршин суугаа дээрх иргэдээс эрх нь үүсэж байгаа хамаарал бүхий хүн, эсхүл тэжээгчээ алдсан хүнд хамаарна.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь нийгмийн хамгааллын салбарын байгууллагууд, холбоод болон шүүхийн захиргаан дахь даатгуулсан иргэн болон ажил олгогчийн оролцооны асуудлаарх Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн заалтад хамаарахгүй.

5 дугаар зүйл Тэтгэмжийн гадаад дахь төлбөр

1. Энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тогтоосон тэтгэмжийг тухайн хүн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт оршин суугаа, эсхүл амьдарч байгаа гэсэн үндэслэлээр бууруулах болон өөрчлөхгүй.
2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу олгох тэтгэмжийг Хэлэлцэн тохиролцогч хоёр талын нутаг дэвсгэрээс гадуур оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын иргэнд Хэлэлцэн тохиролцогч хоёр талын нутаг дэвсгэрээс гадуур оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч эхний талын иргэний нэгэн адил нөхцөл, хэмжээгээр олгоно.
3. Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн тухайд энэ зүйлийн 1 дэх хэсэг нь худалдан авах чадварыг тогтвортой байлгах үүднээс олгодог нэг удаагийн мөнгөн төлбөр болон нөхөн олговрын нэмэлт төлбөрт хамаарахгүй.

II БҮЛЭГ ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ

6 дугаар зүйл Ерөнхий заалт

Энэхүү Хэлэлцээрийн 7 болон 8 дугаар зүйлд заасныг үндэслэн, Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан, эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгч уг ажлынхаа тухайд тухайн Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжид хамаарна. Тухайн ажилтны ажил олгогч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт байрлаж байгаа тохиолдолд энэ заалт мөн хамаарна.

7 дугаар зүйл Тусгай заалтууд

1. Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын нутаг дэвсгэрт 1 сараас доошгүй хугацаанд ажил олгогчид хөдөлмөр эрхэлсэн ажилтныг тухайн ажил олгогч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт тодорхой ажил гүйцэтгүүлэхээр томилсон бол энэхүү хөдөлмөрийн харилцааны тухайд, уг ажилтан Хэлэлцэн тохиролцогч эхний талын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж байгаа мэтээр тухайн талын хууль тогтоомжийг мөрдлөг болгох бөгөөд ингэхдээ хөдөлмөр эрхлэх хугацаа нь 60 сараас хэтрэхгүй байна.
2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэр дэх ажил олгогчоос гуравдагч орны нутаг дэвсгэрт томилогдсон хүн нь тухайн гуравдагч орны нутаг дэвсгэрээс Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт томилогдсон бол энэ зүйлийн 1 дэх хэсэг хамаарна.
3. Томилогдсон ажилтан Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт өөр ажил олгогчтой нэмэлт хөдөлмөрийн гэрээ байгуулсан, эсхүл хувиараа хөдөлмөр эрхэлсэн бол тухайн нэмэлт хөдөлмөрийн харилцаа, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн тухайд 6 дугаар зүйл үйлчилнэ.
4. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн үйлчлэлд хамаарал бүхий хүн 60 сарын хугацаанд дундаа тасарсан, мөн өмнөх томилгоо дууссанаас хойш нэг жил болоогүй бол энэ зүйл дахин хамаарахгүй.
5. Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт байрлалтай агаарын тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага нь энэ зорилгоор ажилтнаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт томилон ажиллуулахад 60 сарын хязгааргүйгээр энэ зүйлийн 1 дэх хэсэг үйлчилнэ.

6. Хэлэлцэн тохиролцогч нэг талын далбааг мандуулсан хөлөг онгоцонд цалин хөлстэй хөдөлмөр эрхэлж байгаа хүн Хэлэлцэн тохиролцогч тухайн талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
7. Хэлэлцэн тохиролцогч нэг талын төрийн албан хаагч, түүнтэй адилтгах албан хаагч нь түүнийг ажиллуулж байгаа төрийн байгууллагын харьяалах Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
8. Энэхүү Хэлэлцээр нь 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Дипломат харилцааны тухай Венийн конвенц, эсхүл 1963 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Консулын харилцааны тухай Венийн конвенцын заалтад нөлөөлөхгүй.

8 дугаар зүйл

Хэрэглэгдэх хууль тогтоомжийн заалтаас онцгой тохиолдол

Ажилтан, түүний ажил олгогч, эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хүсэлтээр Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд нь зөвшилцсөний үндсэн дээр тухайн ажлын чанар, нөхцөл байдлыг харгалзан энэхүү Хэлэлцээрийн 6 болон 7 дугаар зүйлд үл хамаарах онцгой тохиолдлын талаар харилцан тохиролцож болно.

III БҮЛЭГ

ТЭТГЭМЖИЙН ТАЛААРХ ЗААЛТУУД

9 дүгээр зүйл

Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох

1. Хэрэв тухайн хүн Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацаатай бол тэтгэмж авах эрхийг тодорхойлох зорилгоор шаардлагатай тохиолдолд эрх тодорхойлох Хэлэлцэн тохиролцогч тал нь эдгээр хугацааг өөрийн талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаа мэтээр нэгтгэн тооцно.
2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тусгай схемийн хүрээнд тодорхой мэргэжлийн төрөлд, эсхүл тухайлсан ажил, хөдөлмөр эрхлэлтэд даатгалын шимтгэл төлсөн хугацааг харгалзан тэтгэмж олгодог бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу зөвхөн ижил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд даатгалын шимтгэл төлсөн хугацааг тухайн тэтгэмжийг олгохдоо харгалзан үзнэ.

3. Хэлэлцэн тохиролцогч нэг тал нь нийгмийн хамгааллын тухай ижил төрлийн хэлэлцээр байгуулсан гуравдагч улсад даатгалын шимтгэл төлсөн хугацааг зөвхөн Хэлэлцэн тохиролцогч тухайн тал нь тэтгэвэр олгох эрхийг тодорхойлох зорилгоор харгалзан үзнэ.
4. Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэврийн төлбөрийг олгосон хугацаа нь даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг уртасгахаар заасан тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авсан хугацаагаар дээр дурдсан даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг уртасгана.

10 дугаар зүйл

Нэг жилээс доош даатгалын шимтгэл төлсөн хугацаа

Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тэтгэмж тогтоох зорилгоор харгалзан үзэж байгаа даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь 12 сараас бага бөгөөд тухайн хууль тогтоомжийн дагуу уг хугацаанд тэтгэмж олгох эрх үүсэхгүй бол Хэлэлцэн тохиролцогч тухайн талын хууль тогтоомжийн хүрээнд тэтгэмж олгогдохгүй.

11 дүгээр зүйл

Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцохгүйгээр тэтгэмжийг тооцоолох

Хэрэв Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу энэ Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоох эрх үүсэж байвал Хэлэлцэн тохиролцогч тухайн талын эрх бүхий байгууллага нь өөрийн талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд үндэслэн тэтгэмжийн хэмжээг тогтооно.

12 дугаар зүйл

Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцсоны дараа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэврийг тооцоолох

1. Энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлд заасныг баримтлан Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэврийн эрх үүссэн бол эрх бүхий байгууллага нь тэтгэврийг дараах байдлаар тодорхойлно:
 - а) шимтгэл төлсөн бүх хугацааг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн мэтээр тооцож, тэтгэврийн онолын хэмжээг тооцоолно;
 - б) энэ хэсгийн а) заалтад дурдсан онолын хэмжээнд үндэслэн, нийт даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийн бодит хэмжээг тодорхойлно.

2. Тэтгэврийн бодит хэмжээг тодорхойлохдоо Монгол Улсын эрх бүхий байгууллага нь зөвхөн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу авсан цалин хөлс болон төлсөн шимтгэлийг харгалзан үзнэ.

13 дугаар зүйл

Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцсоны дараа Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэмжийг тооцоолох

1. Энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу зөвхөн хугацааг нэгтгэн тооцсоноор Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн хүрээнд тэтгэмж авах эрх үүсэж байвал Бүгд Найрамдах Австри Улсын эрх бүхий байгууллага нь Монгол Улсад төлсөн даатгалын шимтгэлийн хугацааг Европын холбооны бусад улсад даатгалын шимтгэл төлсөнтэй адилтган үзэж, тэтгэмжийн хэмжээг (ЕС) No. 883/2004 журмын дагуу тодорхойлно.
2. Тэтгэмжийг тодорхойлохдоо хүүхэд өсгөсөн хугацааг энэ зүйлийн 1 дэх хэсэгт хамааруулахгүй бөгөөд зөвхөн Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн дагуу харгалзан үзнэ.

IV БҮЛЭГ БУСАД ЗААЛТ

14 дүгээр зүйл Эрх бүхий этгээд хоорондын хамтын ажиллагаа, захиргааны дэмжлэг

1. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд Удирдлагын тохиролцоог байгуулж, энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг тусгана.
2. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон эрх бүхий байгууллага нь өөрсдийн тус тусын эрх мэдлийн хүрээнд:
 - а) энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээний талаар харилцан мэдээлэл солилцоно;
 - б) энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд нөлөөлөхүйц хууль тогтоомжийн бүх өөрчлөлтийн талаар харилцан мэдээлнэ.
3. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон эрх бүхий байгууллага нь хоорондоо, эсхүл хамаарал бүхий хүмүүс, эсхүл тэдний хууль ёсны төлөөллүүд шууд холбогдож болно.

15 дугаар зүйл
Захиргааны болон эрх зүйн туслалцаа

1. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон эрх бүхий байгууллага нь энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ өөрийн хууль тогтоомжоо хэрэгжүүлж байгаа мэт харилцан бие биедээ тусална. Энэхүү туслалцаа нь үнэ төлбөргүй байна.
2. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон эрх бүхий байгууллага нь хүлээж авсан баримт бичиг, эсхүл хүсэлтийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын албан ёсны хэл, эсхүл англи хэлээр үйлдэгдсэн гэсэн шалтгаанаар хүлээн авахаас татгалзаж болохгүй.
3. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллага хооронд хялбар, шуурхай холбогдох харилцагч байгууллагуудыг томилно.

16 дугаар зүйл
Мэдээллийн хамгаалал

1. Шаардлагатай тохиолдолд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талууд хувь хүний мэдээллийг харилцан солилцож болно. Хувь хүний мэдээллийг харилцан солилцох болон боловсруулалт хийхдээ дотоодын холбогдох хууль тогтоомж болон мэдээлэл солилцож байгаа байгууллагуудын гаргасан нөхцөл шаардлагыг баримтална. Хувь хүний мэдээллийг автоматжуулсан болон автоматжуулаагүй аргаар боловсруулахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - а) Хувь хүний мэдээллийг хуулийн дагуу, үнэн зөв, ил тод байдлаар боловсруулна. Мэдээллийг зөвхөн энэхүү Хэлэлцээрийн хүрээнд, хууль ёсны, тодорхой зорилгод нийцүүлэн боловсруулна. Мэдээлэл нь тухайн боловсруулсан зорилгод нийцсэн, уг зорилгоос хэтрээгүй байна.
 - б) Хувь хүний мэдээллийг шилжүүлж байгаа Хэлэлцэн тохиролцогч тал бусад зорилгоор боловсруулах талаар тусгайлсан зөвшөөрөл олгоогүй бол уг мэдээллийг зөвхөн тухайн зорилгод нийцүүлэн боловсруулна.
 - в) Хувь хүний мэдээлэл нь үнэн зөв байх бөгөөд шаардлагатай тохиолдолд шинэчлэгдэж байна. Мэдээллийг тухайн зорилгоор боловсруулахдаа хувь хүний мэдээллийн алдааг устгах, эсхүл засах бүхий л зохих арга хэмжээг тухай бүр шуурхай авч

хэрэгжүүлнэ. Шилжүүлсэн хувь хүний мэдээлэл нь алдаатай, шилжүүлж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжид нийцэхгүй байвал уг шилжүүлсэн байгууллага нь хүлээн авсан байгууллагад энэ талаар нэн даруй мэдэгдэнэ. Энэ тохиолдолд хүлээн авч байгаа байгууллага нь уг мэдээллийг засах, эсхүл устгах арга хэмжээг нэн даруй авна.

- г) Хувь хүний мэдээллийг тухайн боловсруулагдсан зорилгод зааснаас илүүгүй хугацаанд уг мэдээллийн субъектийг таньж болохуйц хэлбэрээр хадгална.
2. Хувь хүний мэдээллийг хууль бусаар, зөвшөөрөлгүйгээр боловсруулах, санамсаргүй байдлаар алдах, устгах, гэмтээхээс хамгаалсан техникийн болон зохион байгуулалтын шаардлагатай арга хэмжээ авах замаар мэдээллийн аюулгүй байдлыг хангахуйц зохистой байдлаар боловсруулж, хадгална.
 3. Шилжүүлж байгаа болон хүлээн авч байгаа байгууллага нь хувь хүний мэдээллийн шилжүүлэг бүрийг бүртгэж, тэмдэглэл хөтөлнө. Энэхүү тэмдэглэлд зорилго, агуулга, шилжүүлсэн болон хүлээн авсан хугацаа, шилжүүлсэн, хүлээн авсан байгууллагыг тусгасан байна. Хувь хүний мэдээллийг устгахад мөн адил тэмдэглэл хөтөлнө. Энэхүү тэмдэглэлийг зөвшөөрөлгүй, бусад хэлбэрээр зохисгүй ашиглахаас хамгаалах арга хэмжээг авах бөгөөд 3-аас доошгүй жилийн хугацаанд хадгална. Энэхүү тэмдэглэлийг зөвхөн мэдээлэл хамгаалах дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор ашиглана.
 4. Мэдээллийн эзэн өөрийгөө баталсны үндсэн дээр хувийн мэдээллийг нь боловсруулах асуудал хариуцаж байгаа байгууллагаас уг мэдээллийг энэ Хэлэлцээрийн хүрээнд шилжүүлсэн, боловсруулсан талаар, мэдээллийн эх үүсвэр, хүлээн авагч, хүлээн авагчийн төрөл, зорилго болон хуулийн үндэслэлийн талаар мэдээлэл авах эрхтэй. Уг мэдээллийг саадгүй, үнэ төлбөргүй, ойлгомжтой хэлбэрээр олгоно.

Мөн мэдээллийн эзэн нь зөрүүтэй хувийн мэдээллээ залруулсан болон хууль бусаар боловсруулсан хувийн мэдээллийг устгасан талаарх мэдээллийг авах эрхтэй.

Улмаар мэдээллийн эзний мэдээлэл хамгаалагдах эрх нь зөрчигдсөн бол Хэлэлцэн тохиролцогч талууд уг мэдээллийн эзнийг хуулийн дагуу байгуулагдсан хараат бус шударга шүүхэд гомдол гаргах эрхээр хангах, мөн мэдээллийн эзэн гомдлоо үр дүнтэйгээр шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд нөхөн төлбөр авах боломжийг эрэлхийлэх нөхцөлөөр хангагдана.



Эдгээр эрхийг баталгаажуулах нарийвчилсан дүрэм, журам нь Хэлэлцэн тохиролцогч талуудын дотоодын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулагдана. Энэхүү эрхийг эдлэх хүсэлт гаргасан тохиолдолд тухайн мэдээллийг боловсруулсан байгууллага нь холбогдох шийдвэр гаргахаас өмнө мэдээллийг шилжүүлсэн байгууллагад уг асуудлаар тайлбар хийх боломж олгоно.

5. Хувь хүний мэдээллийг шилжүүлсэн Хэлэлцэн тохиролцогч талын урьдчилан бичгээр олгосон зөвшөөрлөөр гуравдагч этгээдэд шилжүүлж болно. Уг зөвшөөрлийг шилжүүлсэн Хэлэлцэн тохиролцогч талын дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрсөн тохиолдолд олгоно. Хүлээж авсан хувь хүний мэдээллийн нууцлал хангагдсан байна.
6. Хувь хүний шилжүүлсэн мэдээллийг шилжүүлж авсан зорилгоор ашиглах шаардлагагүй болсон, эсхүл боловсруулалтын үндэслэл дуусгавар болсон даруйд устгана. Хүсэлтийг үндэслэн мэдээлэл устгасан талаар шилжүүлсэн Хэлэлцэн тохиролцогч талд мэдээлнэ.
7. Шилжүүлж байгаа эрх бүхий байгууллагын хүсэлтээр хүлээн авч байгаа эрх бүхий байгууллага нь хүлээн авсан мэдээллийн боловсруулалт, үр дүнгийн талаар мэдээлнэ.

17 дугаар зүйл

Төлбөр ба баталгаажуулалтаас чөлөөлөх

1. Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд мэдүүлсэн баримт бичиг, эсхүл гэрчилгээг бүртгэлийн хураамж, хууль ёсны дагуу төлөх төлбөр, тэмдэгтийн хураамж болон татвараас хөнгөлөх, чөлөөлөх нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомж, эсхүл энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор мэдүүлэх ижил төрлийн баримт бичиг, гэрчилгээнд мөн адил хамаарна.
2. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор мэдүүлэх бүх төрлийн мэдэгдэл, баримт бичиг болон гэрчилгээнд дипломат, эсхүл консулын эрх бүхий этгээдийн баталгаажуулалт шаардахгүй.

18 дугаар зүйл

Өргөдөл, мэдэгдэл, давж заалдах өргөдлийг эрх тэгш авч үзэх

1. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хууль тогтоомжийн дагуу Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий этгээд, эрх бүхий байгууллагад гаргасан аливаа хүсэлт, мэдүүлэг болон давж заалдах өргөдлийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээд, эрх бүхий

байгууллагад гаргасан хүсэлт, мэдүүлэг, давж заалдах өргөдөлтэй адилтган авч үзнэ.

2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу гаргасан тэтгэмж авах хүсэлт нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу тухайн тэтгэмжийг авах хүсэлтийн нэгэн адилаар тооцогдоно. Хүсэлтэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааны талаарх мэдээллийг тусгасан байна. Гэхдээ энэ нь хүсэлт гаргагч Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу олгох өндөр насны тэтгэврээс түдгэлзэх хүсэлтээ илэрхийлсэн бол үйлчлэхгүй.
3. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу аливаа хүсэлт, мэдэгдэл, давж заалдах өргөдлийг тухайн талын эрх бүхий этгээд, эсхүл эрх бүхий байгууллагад тогтоосон хугацаанд мэдүүлдэг бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээд, эсхүл эрх бүхий байгууллагад мөн хугацаанд мэдүүлж болно.
4. Энэ зүйлийн 1-3 дахь хэсгийг хэрэгжүүлэх тохиолдолд хүсэлт, мэдэгдэл, давж заалдах өргөдлийг хүлээн авсан эрх бүхий этгээд, эсхүл эрх бүхий байгууллага нь баримт бичгүүдийг хүлээн авсан өдрийг тусган Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээд, эсхүл эрх бүхий байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

19 дүгээр зүйл Эмнэлгийн үзлэг

Хэрэв Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт түр, эсхүл байнга оршин суугаа хүсэлт гаргагч, эсхүл тэтгэмж авагчийг эмнэлгийн үзлэгт хамрагдахыг шаардсан бол тухайн эрх бүхий байгууллагын хүсэлт болон зардлаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллага нь оршин суугаа нутаг дэвсгэрт эмнэлгийн үзлэгийг зохион байгуулна. Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжийн дагуу эмнэлгийн үзлэгийг зохион байгуулах тохиолдолд түр, эсхүл байнга оршин суугаа талын эрх бүхий байгууллагын зардлаар тухайн эмнэлгийн үзлэгийг зохион байгуулна.

20 дугаар зүйл Харилцаа

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн албан ёсны хэл, эсхүл англи хэлээр харилцана.



21 дүгээр зүйл Төлбөр

1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олгогдох тэтгэмжийн төлбөрийг Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын мөнгөн тэмдэгтээр олгож болно.
2. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олгогдох нөхөн төлбөрийг тухайн үйлчилгээ үзүүлж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын мөнгөн тэмдэгтээр хийнэ.
3. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олгогдох төлбөрийг тухайн төлбөр төлөх үед Хэлэлцэн тохиролцогч талуудад мөрдөгдөж байгаа дүрэм, журмын дагуу олгоно.
4. Хэлэлцэн тохиролцогч нэг тал нь нутаг дэвсгэрээс гадуур оршин суугаа хүнд аливаа төлбөр, гадаад мөнгөн шилжүүлэг, гуйвуулга, эсхүл санхүүгийн хэрэгслийг хязгаарлаж байгаа мөнгөн тэмдэгтийн хяналт, эсхүл түүнтэй адилтгасан арга хэмжээ тогтоосон бол тухайн Хэлэлцэн тохиролцогч тал Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт оршин суугаа энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасан хүмүүст төлбөл зохих аливаа мөнгөн төлбөрийг олгоход шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.

22 дугаар зүйл Илүү болон үндэслэлгүй олгогдсон төлбөр

Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий байгууллага тэтгэмжийн илүү болон үндэслэлгүй төлбөр хийсэн тохиолдолд тухайн илүү болон үндэслэлгүй төлбөрийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу олгогдох тэтгэмжээс хасаж, тухайн эрх бүхий байгууллагын дансанд шилжүүлж болно.

23 дугаар зүйл Маргаан шийдвэрлэх

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх, тайлбарлахтай холбогдон гарсан аливаа маргааныг Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

V БҮЛЭГ ШИЛЖИЛТИЙН БОЛОН ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

24 дүгээр зүйл Шилжилтийн заалтууд

1. Энэхүү Хэлэлцээр нь энэ Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнөх хугацааны тэтгэмжийн төлбөр олгохтой холбоотой эрхийг үүсгэхгүй.
2. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааг энэ Хэлэлцээрийн дагуу эдлэх эрхийг тодорхойлоход харгалзан үзнэ.
3. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнөх хугацаанд тодорхойлсон тэтгэмжийн хэмжээг Хэлэлцэн тохиролцогч талууд шинээр авч үзэхгүй.
4. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө үүссэн эрхтэй холбоотой бусад асуудал энэ Хэлэлцээрт хамаарах бөгөөд харин өмнө нь нэг удаагийн төлбөр авах эрх үүссэн тохиолдолд хамаарахгүй.
5. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олгох тэтгэмжийн хэмжээг энэ Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн тэтгэмж авагчийн хүсэлтээр тодорхойлно. Хэрэв хүсэлтээ энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор мэдүүлсэн бол тэтгэмжийг хүсэлт мэдүүлсэн өдрөөс, харин бусад тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн хууль тогтоомжоор тогтоосон өдрөөс тэтгэмжийг олгоно.
6. Энэхүү Хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хэрэгжүүлэх хүрээнд энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө Хэлэлцэн тохиролцогч нэг талд томилогдсон хүний ажилласан хугацааг энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлснээр тооцно.

25 дугаар зүйл Үргэлжлэх хугацаа болон дуусгавар болох

1. Энэхүү Хэлэлцээр нь хугацаагүйгээр үйлчилнэ. Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал нь 12 сарын өмнө бичгээр гаргасан мэдэгдлийн дагуу Хэлэлцээрийг дуусгавар болгож болно.
2. Хэлэлцээр дуусгавар болсон тохиолдолд Хэлэлцээрийн хүрээнд үүссэн бүх эрх хүчин төгөлдөр хадгалагдана.

3. Хэрэв энэхүү Хэлэлцээр нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу дуусгавар болсон бол энэ Хэлэлцээр дуусгавар болохоос өмнө тэтгэмж авах хүсэлтээ мэдүүлсэн, шаардлагыг хангасан хүмүүсийн тухайд энэ Хэлэлцээрийн дагуу тэтгэмж авах эрх үүсэх, тэтгэмж авах эрх нь хэвээр хадгалагдана.

26 дугаар зүйл
Хэлэлцээр хүчин төгөлдөр болох

1. Хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох дотоодын шаардлагыг хангасан талаар дипломат шугамаар бичгээр харилцан мэдэгдэнэ. Энэхүү Хэлэлцээр нь сүүлийн мэдэгдлийг хүлээн авснаас хойших гурав дахь сарын эхний өдрөөс хүчин төгөлдөр болно.
2. Үүнийг гэрчилж, энэхүү Хэлэлцээрт Засгийн газруудаас бүрэн эрх олгогдсон дараах төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулав.
3. *Улаанбаатар* хотноо 2025 оны 5 сарын 26 -ны өдөр монгол, герман, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарсан тохиолдолд англи хэлээрх эх хувийг баримтална.

**МОНГОЛУЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecele@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4.5

Индекс: 200003

